

128
7

**Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын
Автобаазын талаар авах зарим арга
хэмжээний тухай**

ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Авто бааз нь 48 автомашин хөдлөх бүрэлдхүүнтэй 63 ажилчин, албан хаагчидтайгаар Нийслэл Дүүргийн Засаг даргын Тамгын газар, зарим харьяа газрын албан үйлчилгээнд автомашинуудыг албан, ажлын, дуудлагын гэж ангилан тогтоож, албан тушаалын болон албан ажлын дуудлагын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлуулан, албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоногт/баярын болон долоо хоног бүрийн амралтын өдрийг оролцуулан / дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 80 км—ээс тус тус хэтрүүлэхгүйгээр тогтоосон зарчмыг баримтлан ажиллах хугацаандаа ажилчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх хотын төсвөөс татаас авахгүй байх, автомашин хэрэглэгч бүхий газруудад хөнгөн шуурхай үйлчлэх чиглэлийг баримтлан ажиллалаа.

Автобааз нь 1995 оны 11 сард /хуучнаар эрүүл мэндийн автобааз/-д шилжин ирснээс хойш сантехник үйлдвэрлэлийн байр контор, барилгын засвар, галын хамгаалал, машин засах корпус, ажилчдын цайны газар, гэрэлтүүлэг, диспетчерийн байр, тоног төхөөрөмж шинээр дахин байрлуулах, худалдан авах, хаалга хийх, хашаа барих, гражийн байранд тасалгаа барих, шинээр гар таль 1 комыг хийх зэрэг ажлуудыг шинээр хийж, ажилчдын цалинг 18,2 хувиар нэмэгдүүлэн, ажилчдад хоолны хөнгөлөлт 70 хувийг үзүүлэн, 1997 оны 3-р улирлаар өссөн дүнгээр улсын татварт 6334200 төгрөг, бусад ноогдох татварт 3733506 төгрөг, ажилчдын цалинд 16963678 төгрөг, шагнал урамшуулал тэтгэмжинд 3030321 төгрөг, дулаанд 1619086 төгрөг, цахилгаан, телефонд 659279,80 төгрөг, тослох материалд 1084403,70 төгрөг, дугуй авто сэлбэгэнд 15074299,40 төгрөг, шатахуунд 24573162,00 төгрөг бүгд 73071935,90

төгрөгийг зарцуулжээ. 1996 онд байгууллагын ашгаас "Аксент" автомашин 1 ширхэгийг 6000000 төгрөгөөр, "Газ" 31029 автомашин 1 ширхэгийг 6500000 төгрөгөөр, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, компьютерын сүлжээнд орох зорилгыг баримтлан иж бүрнээр 3 компьютерыг 2472410 төгрөгөөр худалдан авч бүгд 14972410 төгрөгийг зарцуулсан байна.

Автобаазын үйлдвэрлэлийн байр болон засварын зайлшгүй шаардагдах чухал ажлуудыг хийж дуусган, 1997 оны 10 сард гадна дулааны 50 м шугамыг 3643657,00 төгрөгийн материал зарцуулан шинэчлэн ашиглалтанд орууллаа.

Нийслэлийн Засаг даргын 1996 оны А/199-р захирамжаар дүүрэг, харьяа газрын автомашиныг төвлөрүүлснээс одоогийн байдлаар 8 газрын 11 автомашиныг хүлээн авснаас автомашинууд нь 1-4 жил ажилласан 2 автомашин нь онхолдсон, 1 автомашин нь тоногдсон ямарч техникийн комиссын актгүй зөвхөн хүлээлгэн өгч салах ёс гүйцэтгэсэн болно.

Одоо автобааз нь 361 толгой мал сүрэг, 279166010 төгрөгийн үндсэн хөрөнгөтэй парк ашиглалт 90-95 хувьтай, автомашин хөдлөх бүрэлдхүүний 25 хувь нь шинэчлэгдсэн. Бусад автомашинууд нь дунджаар 4-11 жил ажиллаж, хуучирсан, шатахуун сэлбэг, тослох материал, цахилгаан дулааны үнэ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа, хэрэглэгч байгууллагууд тогтоосон км-ийн лимитээр ажил үүргээ явуулах зэргээс үзэхэд авто баазын паркийг түргэн хугацаанд шинэчлэх шаардлагатай байна. /Автомашин хөдлөх бүрэлдхүүний бүртгэлийг хавсралт 1-ээс үзэх /

1995-1996 онд худалдан авсан "Сонота" маркийн автомашинууд нь эвдэрч, сэлбэг худалдан авахад ихээхэн хөрөнгө зарж байгааг анхааран үзэж Монгол улсын Засгийн газрын 1996 оны 286-р тогтоол, автобаазын танилцуулгыг үндэслэн доорхи асуудлыг шийдвэрлэж өгөхийг таниас хүсье.

1. Нийслэлийн Засаг даргын урилгаар болон хотын харьяа газруудад зочин гийчин ирэхэд зочны үйлчилгээний автомашин байхгүй өөр газраас өндөр үнээр автомашин дуудлагаар авч бараг 1 жилд нэг автомашин худалдан авах зардлыг гаргаж байгааг анхааран үзэж зочин гийчний үйлчилгээнд зориулан 2 суудлын автомашин худалдан авах хөрөнгийн эх үүсвэр 22,0 сая төгрөг / Зочны автомашиныг зөвхөн зочин ирсэн үед хэрэглэнэ/.

2. Автобаазын парк ашиглалт хуучирсан, ашиглалтын хугацаа дууссан актлах олон машинуудтай, төрийн захиргааны байгууллагуудад үйлчлэх автомашины тоо хүрэхгүй байгаа зэргийг харгалзан үзэж албан ажил, дуудлагын автомашин хэрэглэгчдэд

зориулан 4 суудлын автомашин шинээр худалдан авах хөрөнгийн эх үүсвэр 50,0 сая төгрөг болон бүгд 72,0 сая төгрөг .

3. Автомашинуудын ажилласан жил, гүйлт, норм, ашиглалтын байдал, зарцуулах сэлбэгийн өртөг зэргийг үндэслэн дэс дараалалтайгаар /хавсралт-1/ дахь автомашинуудыг холбогдох газрын шийдвэрээр худалдан, худалдсан мөнгөний эх үүсвэрээр шинээр автомашин худалдан авах саналтай байна.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэж өгөхийг таниас хүсье.

АВТОБААЗЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Тус автобааз нь 1973 онд ТҮАА-н харьяа хөнгөн тэрэгний хэсэг гэж нэртэй байгаад 1974 онд УБ хотын АДХГЗахиргааны Автограш нэртэй байгуулагдсан.

Энэ үед дарга нь Жигжидсүрэн гэдэг хүн байсан тэр үед граш нь одоогийн 11 хорооллын орчимд байсан. 1977-1978 оны үед Автограш нь бааз болон өргөжиж харьяа газрын машинууд нэмэгдэж ирсэн.

1981 онд бааз нүүж барилгын III баазын хажууд шинээр граш барьж орсон. Манай баазын даргаар Батбаяр, Түвшинбаяр, Лувсан-Очир, Чакерхаан Мижиддорж гэдэг дарга нар байсан.

Ингээд 1988 оны 12 дугаар сарын 1-нд баазуудыг төвлөрүүлсний дагуу манай баазыг тарааж 37-р авто баазад хөнгөн тэрэгнүүдийг, 38-р автобаазад ачааны машин болон автобуснуудыг, 29-р баазад УАЗ маркийн машинуудыг шилжүүлсэн.

Энэ үед нилээд олонхи машинууд 37-р баазад очсон бөгөөд тэндээсээ 1991 оны 8 дугаар сард НААҮЯ-ны авто бааз руу дахин шилжиж ажилласан байна.

1992 онд АДХГЗ-ны 23 дугаар тогтоолоор 36 автомашины бүрэлдхүүнтэйгээр УБ хотын Ардын Де путатуудын Хурлын Гүйцэтгэх захиргааны автобааз /37-р баазын байранд/ ыг байгуулж, даргаар нь Чадраабалын Төрбат ажилласан.

1992-1993 онуудад бааз нь үндсэн хөрөнгө, орон байр байгууламж, тоног төхөөрөмж бүгд 3406065 төгрөгийн 9 маркийн 36 автомашин бүхий парк ашиглалт 40-50 хувьтай ажиллаж байсан. 1993 оны жилийн эцсээр парк ашиглалтыг 60 хувиар шинэчилж, 90 хувьтай болгож, 3 сая төгрөгийн ашигтай ажиллан, 172 толгой бүхий малтай Туслах аж ахуйтай болж, ажилчдын гуанзыг 30 хувийн хөнгөлттэй ажиллуулж, норм дууссан 8 жолоочийн автомашиныг хувьд нь Өмч хувьчлалын зөвшөөрлөөр олгосон байна.

6

**АВТОБААЗЫН ДАРГААР АЖИЛЛАЖ
БАЙСАН ДАРГА НАР:**

1973–1978 онд Жигжидсүрэн

1979 онд Дэмбэрэлдорж

1979–1981 онд Батбаяр

1982–1983 онд Түвшинбаяр

1983–1984 онд Лувсан–Очир

1985–1987 онд Чакерхаан

1987–1988 онд Мижиддорж

1988 оны 12 сарын 01–нээс татан буугдаж 1992 оны 01 сарын 23–ны АДХГЗ–ны 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын АХГЗ–ны автобааз байгуулагдан, даргаар нь Ч.Төрбат томилогдон одоог хүртэл ажиллаж байна.

1994 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын автобааз нэртэй болж 34 автомашин хөдлөх бүрэлдхүүн, 53 ажилчидтай байсан. 1994 он гарсаар байгууллагын цэвэр ашгаас УАЗ-469, УАЗ-452, ГАЗ-31029 автомашинуудыг шинээр худалдан авсан байна. "Онц тээвэрчин" цол тэмдэгтэн 3, "Осолгүй манлай жолооч" цол тэмдгээр 2 жолооч шагнагдсан байна.

1994 онд автобаазын дэргэд "Жолооч бэлтгэх курс", сэлбэгийн дэлгүүрийг нээн ажиллуулж байсан байна.

1995 онд одоогийн энэ газар /хуучин түргэн тусламжийн бааз байсан/ шинээр конторыг засварлуулж, одоогийн бааз маань нүүж ирсэн ба автобаазын даргаар Ч.Төрбат одоог хүртэл ажиллаж байна. Баазын ерөнхий инженер Д.Сундуйжав, ерөнхий нягтлан бодогчоор Я.Эрдэнэцэцэг нийт 60-аад жолооч, ажилчидтай ажиллаж байна.

1996 онд парк ашиглалтыг шинэчилж, байгууллагын ашгаас "АКСЕНТ", ГАЗ-31029 автомашин, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 3 ком компьютер авч, ТАА-н мал өсч 249 толгой малтай болж ажилчдын цайны газарт мах, сүү, айргийг авч хэрэглэж байсан.

1997-2000 онд манай баазын автомашинууд голдуу Оросын машинууд байдаг байсан ба 1996 оноос хойш Солонгос, Японы машинууд ирж, одоо бараг бүх машины 50 хувь нь Солонгос, Японы машинууд болсон.

2000 онд 54 автомашин хөдлөх бүрэлдхүүн, 55 ажилчин, албан хаагчидтай, 599446,6 мян. төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажиллан, 7 жолоочид автомашиныг нь түрээслүүлэн улмаар, Нийслэлийн өмчийн газрын шийдвэрээр автомашиныг нь хувьд нь олгон, 4 ажилтныг орон сууцаар хангаж, Парк ашиглалтыг сайжруулан "Сонота-4" автомашин 2, "Авента" машин 1, "Ниссан патрол" жип, "Тоёото-Ландкрузер" машинуудаар шинэчилсэн.

Нийслэл хот байгуулагдсаны 360 жилийн ойгоор жолооч Д.Баярсүрэн "Алтан гадас" одонгоор, Авто тээврийн 75 жилийн ойгоор жолооч Л.Доржпүрэв "Алтан гадас" одонгоор, автобаазын дарга Ч.Төрбат, инженер Д.Сундуйжав нар "Онц тээвэрчин", диспетчер С.Загар, жолооч А.Сономцэрэн, Л.Нямсүрэн, Б.Алгаа нар "Осолгүй манлай жолооч" цол тэмдгээр болон бусад ажилтан, ажилчид

Нийслэл, дүүрэг, харьяа газруудын шагналаар шагнагдсан. 2000 онд автобааз нь 9123,0 мян.төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ирэх жил 2002 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын автобааз байгуулагдсаны 30 жилийн ойгоо манай хамт олон ажлын өндөр амжилтаар угтахаар ажиллаж байна.

АВТОБААЗЫН АРХИВЫН ТҮҮХ:

Автобааз нь анх 1973 онд байгуулагдсан боловч, энэ хугацаанд олон жижиг авто грашуудтай зохион байгуулалтын өөрчлөлтөөр нийлж, салж, нэгдэж тусгаарлагдан явсаар 1973–1992 он хүртэлх хугацааны архивын баримт гэхээр юм үгүй, тухайн үеийн байгууллагуудад ажиллаж байсан хүмүүсийн хувийн хэргийг л шилжүүлэн авч байсан юм байна. Энэ хооронд тусгай томилсон архив, бичиг хэргийн ажилтан байхгүй, нярав болон нягтлангууд нь ажилтайгаа хавсарч хийж байсан байна.

1996 онд архив, бичиг хэргийн албан ёсны ажилтантай болж, 1992–1995 оны баримтуудыг нягтлангаас нь хүлээн авсан. 1997 онд автобаазын даргын тушаалаар байгууллагын БНШАЗК–ыг 5 хүний бүрэлдхүүнтэй байгуулж, 1992–1996 оны архивын баримтуудыг / боловсон хүчний болон санхүүгийн/ жагсаалтаар хүлээн авсан. Комиссын нэг ажилтан солигдсон тул 1999 оны автобаазын даргын 52 тоот тушаалаар БНШАЗК–ыг шинэчлэн томилсон.

Комисс 1999–12–16ны өдөр хуралдаж 03 тоот протоколын дагуу төлөвлөгөө гарган баримтуудад оны зааг хийж, ҮЖ–ээр хугацаа нь дууссан (1992–1997оны) устгах баримтуудыг түүвэрлэн, төрийн архивт шилжүүлэх талаар Нийслэлийн Архивын албатай харилцаж, хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Нийслэлийн архивын албатай хамтран байгууллагын архивын 1992–1997 оны баримтуудад эрдэм шинжилгээний техник боловсруулалт хийлгэхээр гэрээ байгуулан, үүнээс устгах 42 баримтыг түүвэрлэн, устгуулахаар шилжүүлж, 67 ширхэг баримтад техник боловсруулалт хийлгэн ажилласан.

2000 оны архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гарган, архивын тусгай өрөө, сейф, техник хэрэгсэлтэй болон, үзлэгээр "хангалттай цаашид сайн ажиллах" гэсэн дүгнэлт авсан.

2000-03-10ны өдөр БНШАЗК нь байгууллагын архивын баримтад тооллого хийж, данс бүртгэл, байгууллагын түүхчилсэн лавлахыг шинэчилж, илтгэх хуудсаар Төрийн архивт танилцуулсан.

Байгууллагын "Архивын гэрчилгээ" авах баримт материалуудыг бүрдүүлж Төрийн архивт явуулж, шаардлага ханган, 2000 оны 08 сард байгууллагын "Архивын гэрчилгээ"-г авсан.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВТОБААЗ

Түүхчилсэн лавлахыг бичсэн: Архив, бичиг хэргийн
ажилтан *[Signature]* /Ч.БАЙГАЛЬ/

2001 оны 05 дугаар сарын 08

7
10

АВТОБААЗЫН ГАВЬЯА ШАГНАЛТНУУДЫН СУДАЛГАА /2001–04/

1. "Алтан гадас" одонгоор жолооч Г.Бор
Д.Баярсүрэн , Л.Доржпүрэв
2. "Хөдөлмөрийн хүндэт медаль" Д.Баярсүрэн , Н.Гарамбат ,
Л.Доржпүрэв
3. "Дэд бүтцийн яамны шагнал "
"ОНЦ ТЭЭВЭРЧИН" Д.Баярсүрэн, Л.Доржпүрэв, Ч.Төрбат,
Д.Сундуйжав
4. ДБЯ–ны "Хүндэт жуух" Л.Баясгаланцогт , Ц.Түмэндэмбэрэл
5. Сангийн яамны жуух бичиг Я.Эрдэнэцэцэг
6. Замын цагдаагийн газрын шагнал
"Осолгүй манлай жолооч"
Д.Баярсүрэн Б.Мягмаржав
Б.Баярсайхан Н.Гарамбат
Л.Баясгаланцогт С.Бадрал
Н.Баатар М.Ганхуяг
Г.Батчулуун Д.Дэлхийцэцэг
Ч.Батжаргал Б.Орломжав
Ц.Болд О.Сүрэнхорлоо
Ц.Түмэндэмбэрэл Т.Халтар
П.Ширэндэв Ж.Эрдэнэменх
Д.Сундуйжав Д.Ядамсүрэн
Ш.Воршилов Ч.Эрдэнэ–Очир
С.Загар А.Сономцэрэн
Л.Нямсүрэн Б.Алгаа
7. "МХЗЭ–ийн шагнал " Х.Аюуш /алт/ , Л.Доржпүрэв /мөнгө/
Д.Дэлхийцэцэг /мөнгө/,М.Ганхуяг /мөнгө/
8. "Нийслэлийн Засаг Даргын хүндэт жуух бичиг" Ч.Төрбат ,
Д.Сундуйжав , Ш.Балсанжав, Сүрэнхорлоо , Х.Аюуш, Б.Саранпил ,
Ч.Эрдэнэ–Очир , Г.Батчулуун
9. "НЗДТГ–ын жуух бичиг" Х.Одончимэг, Д.Баярсүрэн, Ч.Батжаргал,
О.Сүрэнхорлоо, А.Сономцэрэн , Ч.Эрдэнэменх, Б.Батхуяг

10. Дүүргүүд, харьяа газрын шагналаар :

Жолооч Н.Гарамбат /НҮГ/ , Д.Баярсүрэн /НҮГ/, Б.Пүрэвжав /НҮГ/ , М.Ганхуяг /НҮГ/ , А.Сономцэрэн /НҮГ/ , Ч.Эрдэнэ–Очир/НҮГ/ , Ш.Балсанжав /НҮГ/, Б.Баярсайхан /НҮГ/ /ЗАА/, Ч.Батжаргал /НҮГ/ , Б.Бат–Отгон/ НИТХ/ , Ц.Батсүх, О.Сүрэнхорлоо /БОГ/, Энхбат /ЧД/, Х.Батсүх/СБД/ ,Н.Отгонбаатар /ГХА/ ,Л.Баясгаланцогт /ССА/ Р.Чинзүрх /ХЗЭГ/, Д.Дэлхийцэцэг /ХУД/ , С.Улаанхүү /БЗД/, Ширэндэв /БЗ ИТХ/, Б.Орломжав /БГ/ , Т.Халтар/ Хотын санхүү/, Ж.Эрдэнэменх /СХД ИТХ/, Б.Сайханбилэг /БОК/ , С.Бадрал /БОК/ , Л.Нямсүрэн /НХШХ/ , Л.Доржпүрэв, Д.Гантөмөр /БГ ИТХ/ , Я.Эрдэнэцэцэг /Хотын санхүү/

11. Ойн медалиудаар :

Д.Баярсүрэн /АХ50,60,70, АТ70 /
Д.Сундуйжав / АХ 50,60,70 , АТ70/
Б.Орломжав /АТ70/
О.Сүрэнхорлоо /АХ60,70/
Л.Доржпүрэв /АХ50,60,70, АТ70/

Н.Гарамбат /АХ50,60, АТ70/
Л.Баясгаланцогт /АТ70/
Ж.Эрдэнэменх /АХ60,70, АТ70/
Я.Цогзолмаа / АХ60,70/

Авто баазын түүхийн хуудаснаас

Автобааз нь 1972 онд Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 87 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын АДХГЗ-ны харъяа суудлын автомашины хэсэг, дараа нь Автограш нэртэйгээр одоогийн 11 дүгээр хорооллын орчимд Нийслэл, захиргааны Тамгын газарт автомашинаар үйлчлэх зорилготойгоор анх байгуулагдаж, энэ үед дарга нь Жигжидсүрэн гэдэг хүн байжээ.

Автограш нь 1977-1978 онуудад БААЗ болон өргөжиж, Улаанбаатар хотын харъяа газруудын машинууд нэмэгдэн ирж, 1981 онд бааз нүүж, Барилгын 3-р баазын хажууд шинээр гарааш барьж орсон байна.

1988 оны 12 дугаар сарын 1-нд нийслэлийн зарим баазуудыг төвлөрүүлсний дагуу 1988-1991 онуудад 2-3 автобаазуудтай нэгдэн нийлж явсаар 1992 онд АДХГЗ-ны 23 дугаар тогтоолоор 46 автомашин хөдлөх бүрэлдхүүнтэйгээр **Улаанбаатар хотын АДХГЗ-ны Автобааз** нэртэй, 1994 оноос **НЗДТГ-ын Автобааз** нэртэйгээр байгуулагдсан түүхтэй.

1992 оноос одоог хүртэл Аж ахуйн тооцоон дээр санхүүгийн үйл ажиллагаагаа явуулж, 1996 оноос хойш Нийслэлийн өмчит УУГ болж 2001 оноос **"Нийслэлийн тээвэр ОНӨААТҮГ"** нэртэйгээр автобааз нь парк ашиглалт, автомашин хөдлөх бүрэлдхүүнийг шинэчлэхэд Нийслэл болон дүүргүүдээс санхүүжилт авч ажиллаж байна.

1992-1994 онуудад автобаазын автомашин хөдлөх бүрэлдхүүн бүгд Оросын машинууд байсныг 1996 оноос хойш Солонгос, Япон улсын автомашинуудаар паркыг шинэчлэн, одоо 100 хувь Япон, Солонгос болон бусад улсын автомашин хөдлөх бүрэлдхүүнтэйгээр НИТХурал, НЗДТГазар, НЗДаргын хэрэгжүүлэгч агентлагууд болон Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд нийт 25 орчим хэрэглэгч байгууллагуудтай автомашинаар "Үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ" байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2003 оны 49 дүгээр захирамжаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын автомашинуудыг төвлөрүүлж, НЗДаргын 2005 оны 02 дугаар захирамжаар авто баазын парк шинэчлэлтийг хийж автомашинууд нэмэгдсэнээр автобаазын 1, 2-р паркийг шинээр ажиллуулах болсон. тул НЗД-ын 2005 оны 11 дүгээр захирамжаар Нийслэлийн Төр Захиргааны 3-р байрны доод талын 20 автомашины авто гараашийг 2-р парк болгон эзэмшиж ажиллаж байна.

Автобааз нь одоо нийт 72 ажиллагсадтай, 63 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэй, 1333352.0 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажиллаж, Нийслэл хотынхоо хөгжилд хувь нэмрээ оруулан хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ хөнгөн шуурхай соёлтой үйлчлэн ажиллаж байна.

Манай хамт олны хийсэн ажлын бүтээлийг Төр засаг, Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Нийслэлийн удирдах дээд байгууллагуудаас өндрөөр үнэлж НИТХурал болон НЗДТГ-ын "ӨРГӨМЖЛӨЛ", НҮГ-ын "Хүндэт өргөмжлөл", Налайх дүүргийн "Хүндэт өргөмжлөл"-өөр автобаазыг шагнаж урамшуулсан бөгөөд ажилтан, албан хаагчид, жолооч нараас Хөдөлмөрийн гавъяаны Улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 5, Хөдөлмөрийн хүндэт медалиар 7, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналаар 15, Нийслэлийн Хүндэт тэмдгээр 6, Ахмад тээвэрчин 8, Онц тээвэрчин 25, ЗЦГ-ын "Осолгүй манлай жолооч" цол тэмдгээр 28, НЗДТГ-ын Хүндэт жуухаар 12, МЗХ-ны "Хөдөлмөрийн алдар" алтан медалиар 5, НХЗГ-ын "Шилдэг залуу" алтан медалиар 8 болон бусад харьяа байгууллагуудын шагналаар тус тус шагнасан байна.

9/9 - 19 X - 221

B

/төрийн архивын нэр /

Нийслэлийн төр захиргааны авто бааз

/байгууллагын нэр/

Хөмрөг №
Данс №
ХН №

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Эхэлсэн он, сар, өдөр 2001 он.
Дууссан он, сар, өдөр 2008 он.
Хуудасны тоо 22
Хадгалах хугацааны жагсаалтын зүйлийн
дугаар ВН-57/а, байнга

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ

д/д	Нэрийн өөрчлөлт	Он
1	Улаанбаатар хотын АДХГЗ-ны Авто бааз	1992 он
2	НЗДТГ-ын Авто бааз /НӨУҮГ/	1994 он
3	Нийслэлийн төр захиргааны авто бааз /ОНӨУҮГ/	2007 он
4	Нийслэлийн төр захиргааны авто бааз /ОНӨУТҮГ/	2008 он

Нэг. Хөмрөг үүсгэгчийн түүх

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1972 оны 87 тоот тогтоолоор Нийслэл, захиргааны тамгын газарт автомашинаар үйлчлэх зорилготойгоор анх байгуулагдаж 1992 онд АДХГЗ-ны 23 дугаар тогтоолоор 46 автомашин хөдлөх бүрэлдхүүнтэйгээр **Улаанбаатар хотын АДХГЗ-ны Автобааз** нэртэй, 1994 оноос **НЗДТГ-ын Авто бааз**, 2007 оны 10 дугаар сараас **НТЗ-ны Авто бааз** нэртэйгээр байгуулагдаж , нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар болон өргөжиж Авто баазын даргаар Нийслэлийн засаг даргын 2003 оны 07-р сарын 23-ний өдрийн 298 тоот захирамжийн дагуу Цэрэнбат овогтой Батхуяг томилогдон ажиллаж байна. Тус байгууллага нь 2008 онд 1178966.5 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 573920.6 мян.төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

- **Байрлал** : Сүхбаатар дүүрэг 10-р хороо 7-р хороололд байрлах өөрийн байгууллагын байранд
- **Хуулийн этгээдийн эрх зүйн байдал** : Улсын бүртгэлийн гэрчилгээ 9070002070 , регистер 2117169
- **Өмчийн харьяалал** : Нийслэлийн өмч
- **Үйл ажиллагааны чиглэл** : НИТХ, НЗДТГ , дүүргүүдийн ЗДТГ болон харьяа байгууллагуудад автомашинаар үйлчлэх үүрэгтэй ажилладаг.

Эрхэм зорилго

Хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ хөнгөн шуурхай соёлтой үйлчилж, байгууллагын ажилчдынхаа амьдралын түвшинг дээшлүүлэхэд оршино.

АВТО БААЗЫН ТҮҮХЭЭС....

НЗДТГ-ЫН АВТО БААЗ 2001 ОНД

Авто бааз нь 2001 онд нийт 52 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэй, 52 ажилчин, албан хаагчидтай 696141,3 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр парк ашиглалтыг 80-90 хувьтай ажиллуулж ирсэн байна.

2001 онд автобаазын үйл ажиллагааны зардлын тооцоог өмнөх оныхтой харьцуулан оновчтой тодорхойлон гаргаж, бүх ажилтан, албан хаагчидтай Монгол улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн дагуу Хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулан, байгууллагын дотоод журам, сахилга дэг журмын талаар тушаал шийдвэр гарган, ажилтан, албан хаагчдын ажлын үүрэг хариуцлагын заавар журмуудыг шинэчлэн боловсруулан баталж, ажилдаа мөрдлөг болгон ажиллалаа.

"Авто техникийн улсын үзлэг-2001"-д бүх автомашин хөдлөх бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж амжилттай дүн үзүүлж, бензин шатахууны үнэ нэмэгдэж байгаа үед үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд асуудал оруулж шийдвэрлүүлэн, НЗД-ын А/43 захирамжийн дагуу "Автомашин түрээсээр эзэмших гэрээ"-г 4 жолоочтой байгуулан, автомашиныг нь хувийн нь эзэмшилд олгуулах асуудлыг шийдвэрлэж, авто баазын парк шинэчлэлтийг сайжруулах тооцоо судалгаа хийж, Нийслэлийн Засаг даргаар шийдвэр захирамж гаргуулан шинээр "Тоёото-Ландкрузер-100" маркийн автомашин нэг, бусад газраас "Сонота" маркийн хоёр автомашиныг балансаас балансад шилжүүлэн авсан.

Авто баазад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан өндөр настнуудыг Сар шинийн баяраар хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн 725.5 мян.төгрөг зарцуулан сэтгэл санааны болон санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлжээ.

Ажилчдын амьдралыг судлан үзэж, 0-8 насны хүүхдүүдэд Эх үрсийн баяраар 226.0 мян.төгрөгийн шагнал, урамшил, бэлэг олгож, гэрт амьдардаг 25 ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт 440.0 мян.төгрөг, ах дүү, төрөл төрөгсөд нь нас барсан үед сэтгэл санааг нь хуваалцан 325.0 мян.төгрөгийн буцалтгүй тэтгэмж, хамт олноос 176.5 мян.төгрөгийг хандивласан байна.

Санхүү

Автобаазын санхүү нь 2001 онд тодорхой ажлуудыг төлөвлөн явуулж, 140503.8 мян.төгрөгийн орлого олж, 6609.9 мян.төгрөгийн ашигтай ажиллаж, Нийслэлийн Санхүүгийн Хяналт, шалгалтын албанаас 1998, 1999, 2000 оны 1-р

улирлын санхүүгийн үйл ажиллагааг шалгасан бүрэн хэмжээний шалгалтанд амжилттай дүн үзүүлээ.

Ардын Их хувьсгалын 80 жилийн ой, Авто тээвэрчдийн баяраар улсад болон авто тээврийн байгууллагад он удаан жил идэвхи, зүтгэл, үр бүтээлтэй ажилласан жолооч Ж.Эрдэнэмөнх, О.Сүрэнхорлоо нар Дэд бүтцийн салбарын "Онц тээвэрчин" цол тэмдэг, Ч.Төрбат, Д.Сундуйжав, Ш.Балсанжав, Г.Ламзав, О.Сүрэнхорлоо, Ж.Эрдэнэмөнх, С.Бадрал, Б.Баярсайхан, Т.Халтар, Л.Доржпүрэв, Я.Цогзолмаа, Д.Баярсүрэн, Г.Батчулуун нар АХ-ын 80 жилийн ойн медалиар, диспетчер Я.Цогзолмаа НЗД-ын "Жуух бичиг"-ээр шагнагдсан байна.

Хөмрөгийн түүх

Автобаазын архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын талаар нилээд ажлуудыг төлөвлөж ажилласнаар Үндэсний архивын газар, Нийслэлийн Архивын албанаас явуулсан "Архив, албан хэрэг хөтлөлт"-ийн улсын үзлэгт сайн дүгнэгдэж, байгууллагын "Архивын гэрчилгээ", Сертификат авсан. Нийслэлийн захиргааны байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтан нарын дунд зарласан "Ажил мэргэжлийн уралдаан"-д нилээд ажлуудыг бэлтгэж, амжилттай оролцсон.

Архивын улсын үзлэгээр баазын удирдлагтай ярилцаж, архивын өрөөг тусгаарлаж, Архивын зохих заавар журмын дагуу баримтуудыг хадгалах, хамгаалах, хөтлөх, ашиглуулах талаар санхүүгийн ажилтнуудад зааварчилгаа өгч, архивын баримтын мэдээг НАА-нд явуулж ажилласан.

Байгууллагын хэмжээнд гаднаас ирсэн бичиг, явуулсан бичигт тогтмол бүртгэл хөтөлж, нийт 45 бичиг ирснийг бүртгэлд авч, хариуг шийдвэрлүүлэн, дээд газраас ирсэн 16 захирамж, тогтоолыг танилцуулж, биелэлтийг улирал бүрээр гаргаж НЗДТГ-т явуулж, бусад албан газруудад 144 дугаар бүхий 195 хуудас албан тоот, 9 дугаар бүхий 14 хуудас тодорхойлолт, захиргааны хурлын тэмдэглэл 93 хуудас, Даргын 121 дугаар бүхий 175 хуудас тушаал гарч, ажилчдаас нийт 53 өргөдөл, гомдол, 6 тодорхойлолтыг бүртгэж шийдвэрлүүлэн, байгууллагын хэмжээнд дотооддоо "Диспетчерийн рапорт", "Амралт баяр ёслолын үеэр ажилласан автомашины бүртгэл", "Цагийн бүртгэл", "Захиргааны хурлын тэмдэглэл"-ийн хуудсуудыг компьютерт шивж, хэвлэн ашиглуулж, 2001 оны байдлаар нийт хадгаламжийн тоо 184, үүнээс байнга 28, Түр 156, байнга хадгалах хн-ийн 1992-2000 оны баримт, НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 2, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 46 байна.

*Түүхчилсэн лавлах бичсэн:
НЗДТГ-ын Авто баазын
Архив, бичиг хэргийн ажилтан Ч.Байгаль,*

АВТО БААЗ 2002 ОНД

Авто бааз нь 2002 онд нийт 45 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэй, 49 ажилтан, албан хаагчидтай 764743,4 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр парк ашиглалтыг 85-90 хувьтай ажиллуулж ирсэн байна.

2002 оны 01 сарын 25нд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор **АВТО БААЗ БАЙГУУЛАГДСАНЫ 30 ЖИЛИЙН ОЙ-г** тэмдэглэн өнгөрүүлж авто баазын тулгын чулууг тавилцсан азай буурлууд болон нийт ажиллаж байгаа ажилтан, ажилчид тэдний гэр бүл, үйлчлүүлэгч байгууллагууд, нийслэлийн төрийн захиргааны газруудтай 30 жилийн ойгоо амжилттай тэмдэглэн өнгөрүүллээ. Улаанбаатар хотын АДХГЗ-ны Авто бааз нэртэй байгуулагдсанаас хойш эдүгээ хүртэл 30 жилийн түүхийг өнгөрүүлсэн ч байгууллагын нийт ажилчдын 60 хувийг мэргэжил боловсролтой залуучууд эзэлж байна.

Эрхэм зорилго

Хэрэглэгч, үйлчлүүлэгчиддээ хөнгөн шуурхай соёлтой үйлчилж, байгууллагын ажилчдынхаа амьдралын түвшинг дээшлүүлэхэд оршино.

гэж байгууллагынхаа үйл ажиллагааны эрхэм зорилго, чиг үүргийг тодорхойлж, Төрийн үйлчилгээнд хөнгөн шуурхай соёлтой үйлчилж, ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлж, хамт олныг сайн удирдан зохион байгуулж байгаа нь энэ байгууллагыг 10 гаруй жил удирдаж байгаа авто баазын дарга Ч.Төрбатын гавъяа зүтгэл бөгөөд нийслэлийнхээ хөгжил, цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж байгаа манай хамт олны хөдөлмөрийн үр шим билээ.

Авто баазын 30 жилийн ой угтсан, ажлын өндөр бүтээлийн болон спортын уралдаан тэмцээн, авто баазын билэгдэл \эмблем, лого\ той болгох үүднээс уралдаан зарлаж, олон загварууд дотроос баазын дарга Ч.Төрбатын хийсэн загвар шалгарч өөрийн гэсэн байгууллагын эмблемтэй болсон. \зураг 1\

Авто баазын 30 жилийн ойгоор Өндөр настнуудад хүндэтгэл үзүүлж 380,0 мян.төгрөгийн шагнал, гарын бэлгээр урамшуулж, ажилчдыг ой угтаж хийсэн ажлын үзүүлэлт, үр дүнгээр шалгаруулан яам, тусгай газар, Нийслэлийн харьяа газруудын шагналаар шагнаж урамшуулсан. Үүнд:

НИТХ-ын "Хүндэт үнэмлэх"-ээр жолооч Л.Доржпүрэв, О.Алдархишиг, нярав Б.Саранпил, нийслэлийн "Хүндэт тэмдэг"-ээр жолооч Д.Баярсүрэн, НЗД-ын "Жуух бичиг"-ээр ня-бо Я.Эрдэнэцэцэг, слесарь Ш.Балсанжав, манаач Н.Пүрэвсүрэн, Авто баазын "Хүндэт Өргөмжлөл"-өөр инженер Д.Сундуйжав, 2001 оны "Хөдөлмөрийн аварга" –аар жолооч Ц.Батхуяг, Дэд бүтцийн яамны "Онц тээвэрчин" цол тэмдгээр жолооч Т.Халтар, Л.Баясгаланцогт, С.Бадрал, мөн яамны "Хүндэт жуух"-аар жолооч Г.Батчулуун, Б.Баярсайхан, Ч.Эрдэнэ-Очир, архив-бичиг хэрэг Ч.Байгаль, АТГ-ын

18

"Хүндэт Өргөмжлөл"-өөр инженер Д.Сундуйжав, мөн "Хүндэт жуух"-аар диспетчер Х.Аюуш, жолооч Ч.Батжаргал, Б.Орломжав, "Осолгүй манлай жолооч" цол тэмдгээр жолооч Ц.Батхуяг, Ц.Батсүх, МЗХ-ны "Хөдөлмөрийн алдар" алтан медалиар жолооч Ч.Эрдэнэмөнх, А.Нэргүйбаатар, ня-бо Я.Эрдэнэцэцэг, Х.Одончимэг, АБХ Ч.Байгаль, Сүхбаатар дүүргийн ИТХ-ын "Өргөмжлөл"-өөр Ш.Балсанжав, Баянзүрх дүүргийн ИТХ-ын "Өргөмжлөл"-өөр Б.Орломжав, СБД-ийн "Хүндэт тэмдэг"-ээр диспетчер-механик Я.Цогзолмаа, жолооч Ж.Отгонбаяр нар тус тус шагнагдан ойг тэмдэглэн өнгөрүүлэх зардалд 2014,6 мян.төгрөг зарцуулсан байна.

2002 оныг Улаанбаатар хотын тохижилтын жил болсонтой холбогдуулан Сүхбаатар дүүргийн Тохижилт үйлчилгээний компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан төлөвлөгөө, төсөв гарган орчин тойрны тохижилт, цэвэрлэгээ хийн, зүлэг мод тарьж, байгууллагын конторын дулаанд тоолуур тавьж, холбоо утсан харилцаанд лимит тогтоосноор дулаан, холбоо, цахилгаан, усны алдагдлыг багасгаж сард 300,0-400,0 мян.төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Авто техникийн үзлэгт амжилттай дүгнэгдэж, ажлын байрыг аттестатчлах шалгалтанд 93 хувиар шалгагдаж, диспетчер, манаач нарын ажлын байрыг шинэчлэн засварлаж, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу Өмчийн харилцааны газрын дуудлага худалдаагаар 10 автомашиныг худалдаж, ашгаар нь сэлбэгээр дутагдаж байгаа бусад авто машинуудаа засварлаж, нийслэл, дүүргүүдийн ажил үйлчилгээг алдагдуулахгүй ажиллан "Авто машин түрээсээр эзэмших гэрээ"-ээр 2 автомашиныг жолоочид нь өмчлүүлж олгуулсан.

Санхүүгийн ажлын талаар :

Авто баазын санхүү нь 2002 онд тодорхой ажлуудыг төлөвлөн, нийт 138497.6 мян.төгрөгийн орлого олж, 218,0 мян.төгрөгийн ашигтай ажиллан, гэрт амьдардаг орлого багатай гэр бүлийн судалгааг гарган, 24 ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт, ажилчдын хүүхдүүдэд 297,0 мян.төгрөгийн бэлэг олгож, өндөр настнуудад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлсэн байна.

Хөмрөгийн түүх

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэж, дээд гарзаас ирсэн захирамжийн биелэлтийг НЗДТГазарт улирлаар гарган явуулж, гаднаас ирсэн бичиг, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлсэн.

2002 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 225, үүнээс байнга 33, түр хадгалах баримт 192, НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 3, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 11 байна.

*НЗДТГ-ын Авто баазын
Архив, бичиг хэргийн ажилтан Ч.Байгаль,*

АВТО БААЗ 2003 ОНД

Авто бааз нь 2003 онд нийт 51 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэй, 59 ажилтан, албан хаагчидтай 833795,8 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр парк ашиглалтыг 88-90 хувьтай ажиллуулж ирсэн байна.

2003 оныг "Бүтээн байгуулалт- хөрөнгө оруулалтын жил" болгосонтой холбогдуулан нилээд ажлуудыг төлөвлөж бүгдийг амжилттай хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Авто баазын гараашид Галын дохиолол "ППС-1"-ийг иж бүрнээр нь суурилуулан тавьж, автомашинуудын түлхүүрийг нэгдсэн хайрцагтай болгож энэ ажилд 650,0 мян.төгрөг ,

2. Авто баазын гэрэлтүүлэг , цахилгааны шугамыг нэгдсэн системд холбох, кабелийн нүх ухах, кабелийг шинээр солих, шинээр монтажлах ажлыг хийж гүйцэтгэхэд 5.1 сая төгрөг ,

3. Дулааны шугамыг бүрэн солих, конторын дээвэрт засвар хийж, конторын нэг өрөөг шинээр засварлах, ажилчдын цайны газарт дотор заслыг хийж энэ ажилд 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2003 онд байгууллагын ажилчдын цалин хөлсийг 6,6 хувиар нэмэгдүүлэн жолооч нарын тооцоог графикийн дагуу авч, МУ-ын Засгийн газрын 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 135 дугаар захирамжийг бүх ажилтан, жолооч нарт танилцуулан автомашинуудын зохицуулалт, хувиарлалтыг хийж , автомашины шатахууны зарцуулалтыг хэмнэх, түүнд хяналт тавих зорилгоор автомашины 100 км-т зарцуулах шатахууны үндсэн норм, 100 т\км ажилд зарцуулах шатахууны норм, хүйтний улиралд нэмэгдүүлсэн хэмжээг шинэчлэн баталж ажиллалаа.

Нийслэлийн Засаг даргын 2003 оны 49 дүгээр захирамжийн дагуу Нийслэл, дүүргүүдийн Мэргэжлийн хяналтын албадаас төвлөрүүлсэн 8 автомашиныг хүлээн авч, засвар үйлчилгээг хийж 6 автомашиныг ажилд оруулан, цаашид ашиглагдахгүй болсон 2 автомашиныг холбогдох материалыг бүрдүүлж Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дуудлага худалдаагаар оруулж шийдвэрлэсэн.

2003 оны 07 дугаар сарын 23-нд авто баазын дарга Чадраабалын Төрбат өөр ажилд шилжиж, баазын даргаар Цэрэнбатын Батхуяг томилогдож ажилласан.

Авто бааз нь 2003 оны 3-р улирлаас парк шинэчлэлтийг хийж Нийслэлийн Засаг даргын 326 дугаар захирамж \Авто баазын талаар авах зарим арга хэмжээ\ ийн дагуу шинээр "Даймлер-Бенз-С200К", "Дэу-Магнус" суудлын автомашин тус бүр нэгийг, "Ниссан Саппоро" жип автомашинуудыг балансаас балансад шилжүүлэн авч, 762750 төгрөгийн үнэ бүхий "Самсунг Мастер 551-S" маркийн иж бүрэн компьютер , 848084 төгрөгийн үнэ бүхий ширээ, сандал, сейф, шкаф зэрэг эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, санхүүгийн ажилд хэрэглэж, МУ-ын СЭЗСайдын 2003 оны 01 тоот албан даалгаврын дагуу санхүүгийн тусгай төлөвлөгөө гарган 8 төрлийн ажлыг хийж, эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор нийт 774964379,10

төгрөгийн эд хөрөнгийг биет байдлаар тоолж, жилийн эцсийн тайлан тэнцлээр 177867,7 мян.төгрөгийн орлоготой ажилласан байна.

Авто баазын парк ашиглалтыг сайжруулах зорилгоор автомашин хөдлөх бүрэлдэхүүнийг 100 хувь Япон, Солонгос улсын автомашин болгож, зарим машинуудад ховор олдохгүй байгаа сэлбэг хэрэгслийг захиалан авчирч, парк ашиглалтыг 90-95 хувьд хүргэж, бүх машинуудыг УБЗ.... дугаартай болгох талаар дорвитой ажил зохион, НИТХурал, НЗДТГазар, НЗДаргын хэрэгжүүлэгч агентлагууд, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд нийт 25 орчим хэрэглэгч байгууллагуудтай "Автомашинаар үйлчлэх гэрээ" байгуулан ажиллаж байна.

2003 оны жилийн эцсийн тайлангийн хурлаар жилийн ажлын үзүүлэлтээр Авто баазын "2002 оны Хөдөлмөрийн Аварга" жолоочоор Х.Батболд Аваргын өргөмжлөл, сарын үндсэн цалингаар , жолооч Л.Доржпүрэв, М.Мөрөндэлгэр, Ч.Эрдэнэмөнх, Ц.Батсүх нар удаах байруудад шалгарч, идэвхитэй сайн ажиллсан жолооч Т.Халтар, Б.Баярсайхан, С.Бадрал, Б.Цогоо нарыг шагнаж урамшуулсан байна.

Хөмрөгийн түүх

2003 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 259, үүнээс байнга 38, түр хадгалах баримт 221, НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 3 , түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 63, Байнга хадгалах ХН-ийн оны хязгаар 1992-2002 он. Төрийн архивт шилжүүлэх хадгалах хугацаа нь гүйцсэн хн-ийн 1996-1999 оны 16 баримтыг ББНШК-ын хурлаар хэлэлцэж, нягтлан шалгалт хийгээд Төрийн архив /НАГ/-аас зөвшөөрөл авсны үндсэн дээр акт үйлдэн, устгал хийсэн байна. Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр, захирамжийн биелэлтийг улирал тутам гарган НЗДТГ-т хүргүүлж, байгууллагын баримт эргэлтийн мэдээг жилийн эцсийн байдлаар гаргаж ажилласан.

Түүхчилсэн лавлах бичсэн:

НЗДТГ-ын Авто баазын

Архив, бичиг хэргийн ажилтан Ч.Байгаль,

АВТО БААЗ 2004 ОНД

Авто бааз нь 2004 онд 53 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэй, 62 ажилтан, албан хаагчидтай, 1024454,4 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажиллаж ирлээ.

Байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн ажлын талаар төлөвлөсөн ажлуудыг хийж гүйцэтгэн, автомашин хөдлөх бүрэлдэхүүн, парк ашиглалтыг шинэчлэх зорилгоор НЗД-ын 2004 оны 134 дүгээр захирамжийн дагуу Тендер шалгаруулж, шинээр бага оврын ачааны автомашин 1-ийг, суудлын Бенз- 230 маркийн автомашин 2-ыг автомашин солилцооны журмаар, НИБМА-ны Тоёото-ландкрузер-80 жип, Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын Пажеро-ММС маркийн автомашинуудыг балансаас балансад шилжүүлэн авч, шатахууны үнэ нэмэгдэж байгаа талаар НЗД-ын зөвлөлийн хуралд асуудал оруулан үйлчилгээний үнэ тарифыг 2004 оны 09 дүгээр сарын 01-нээс нэмэгдүүлэн мөрдөж, Төр захиргааны үйлчилгээнд явахад шаардлага хангахгүй, хугацаа норм нь хэтэрсэн, шатахуун ихээр хэрэглэдэг авто машинуудыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт асуудлыг оруулж Уаз-3909, Уаз-469, Газ-31029, Бенз-190 маркийн автомашинуудыг дуудлага худалдаанд оруулж, Баянзүрх дүүргийн Тохижилт компаниас Тоёото-ландкрузер маркийн 02-08 УБЗ, Делика 00-30 УБД машинуудыг балансаас балансад шилжүүлэн авч ажилласан байна.

Нийслэл хот байгуулагдсаны 365 жилийн ой, Авто тээврийн байгууллагын ой угтсан төлөвлөгөөт ажил, уралдааныг зохион байгуулж ажлын өндөр амжилт гаргасан жолооч, ажилчдыг Нийслэлийн болон салбарын, харьяа газрын шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд:

НИТХ-ын "Хүндэт үнэмлэх"-ээр жолооч М.Мөрөндэлгэр, М.Бямбадорж, НЗД-ын "Жуух бичиг"-ээр жолооч С.Бадрал, Ж.Отгонбаяр, засварчин Ш.Дэлгэрсайхан, Нийслэлийн "Хүндэт тэмдэг"-ээр Н.Гарамбат, "Ахмад тээвэрчин" хүндэт үнэмлэхээр инженер Д.Сундуйжав, жолооч О.Сүрэнхорлоо, Т.Халтар, "Онц тээвэрчин" цол тэмдгээр Н.Гарамбат, Ц.Түмэндэмбэрэл, яамны "Хүндэт жуух"-аар Б.Пүрэвжав, А.Нэргүйбаатар нар, "Осолгүй манлай жолооч" цол тэмдгээр Ж.Отгонбаяр, НИБМА-ны шагналаар Ч.Батжаргал, НХЗГ-ын "Нийслэлийн шилдэг залуу" алтан медалиар дарга Ц.Батхуяг, жолооч Б.Цогоо, нярав Б.Саранпил, ня-бо Х.Одончимэг, НЗАА-ны шагналаар Г.Батчулуун, Х.Ганболд, С.Бадрал, МАСоц ЗХ-ны "Алтан-од" медалиар Ч.Байгаль, Б.Саранпил, Л.Баясгаланцогт, авто баазын мөнгөн шагналаар Г.Билэгт, Н.Ширнэндорж, В.Жанчив, Б.Юра нар шагнагдсан байна.

2004 оны жилийн эцсийн тайлангийн хурлаар жилийн эцсийн ажлын үзүүлэлтээр Авто баазын "2004 оны Хөдөлмөрийн Аварга" жолоочоор Отгоны Манлайжаргал, Аваргын өргөмжлөл, сарын үндсэн цалингаар, жолооч Н.Гарамбат, Л.Доржпүрэв, Б.Юра, М.Мөрөндэлгэр, Х.Батболд нар удаах байруудад шалгарч шагнагдсан байна.

Санхуу

Ажилчдын ахуй амьдралыг дээшлүүлэх зорилгоор ХААН банктай хамтран ажиллах гэрээ байгуулан 5-6 ажилчдад цалингийн зээл олгож, манаач Г.Ламзавт Нийслэлийн Засаг даргын нөөц сангаас 5 ханатай гэр олгуулж, байгууллагын санхүүгийн хэмжээнд 217890,8 мян.төгрөгийн орлого олж ажиллажээ. Санхүүгийн ажлыг сайжруулах зорилгоор санхүүгийн 2 компьютерийн \рам\ багтаамжийг томсгож, орчин үеийн санхүүгийн программыг суулгаснаар татвар болон нийгмийн даатгалын тооцоо, автомашины сэлбэг, бусад материалын орлого, зарлагын тооцоо, үлдэгдлийг баталгаажуулснаар Санхүүгийн 2002-2004 оны баримтын шалгалтанд өр төлбөр, дутагдалгүй шалгуулсан.

Хөмрөгийн түүх

Авто баазын архив, албан хэрэг хөтлөлтийг заавар журам, стандартын дагуу явуулж , Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, ББНШКомиссын дарга Д.Сундуйжав /Ерөнхий инженер/, гишүүд /Я.Эрдэнэцэцэг /ерөнхий ня-бо/, Х.Одончимэг /тооцооны ня-бо/, Б.Саранпил /нярав/ нарийн бичгийн даргаар Ч.Байгаль /архив, бичиг хэрэг/ хурлаар хэлэлцэн, хадгалах хугацаа дууссан баримтуудад нягтлан шалгалтыг хийж , төрийн архиваас зөвшөөрсний дагуу Устгах бичгийн түүвэр жагсаалт, акт үйлдэж 1997, 1998, 1992 оны 24 ширхэг хн-ийг устгалд оруулсан.

Урьд оны баримтуудыг санхүүгийн ажилтнуудаас Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар хүлээн авч , байгууллагын архивыг цэгцлэн, архивын баримтын мэдээ, хийсэн ажлын тайланг Нийслэлийн Архивын газарт явуулсан. 2004 оны байдлаар нийт хадгалажийн нэгжийн тоо 280, үүнээс байнга 44, түр хадгалах хн-ийн тоо 236 , түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 23 болж, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай дүн үзүүлж №06051 тоот "Архивын гэрчилгээ"-г шинээр авсан. Байгууллагын даргын 2004 оны 21 дугаар тушаалаар байгууллагын хэвлэмэл хуудсыг өөрчилж, "Хангарьд"-тайгаар хэвлүүлэн, тамга тэмдэг түших ажилтныг Ч.Байгалиар томилсон.

*Түүхчилсэн лавлах бичсэн:
НЗДТГ-ын Авто баазын
Архив, бичиг хэргийн эрхлэгч Ч.Байгаль,*

НЗДТГ-ЫН АВТО БААЗ 2005 ОНД

Байгууллагын үйл ажиллагаа

Нийслэлийн Засаг даргын 2005 оны 02 дугаар захирамжаар авто баазын парк шинэчлэлтийг хийж автомашинууд нэмэгдсэнээр авто баазын 2-р паркийг шинээр ажиллуулах болсон тул Нийслэлийн Засаг даргын 2005 оны 11 дүгээр захирамжаар Нийслэлийн Төр Захиргааны 3-р байрны доод талын 20 автомашины авто гараашийг 2-р парк болгон эзэмшин ажиллаж, дүүргүүд, НЗД-ын дэргэлэх хэрэгжүүлэгч агентлагуудын авто машинуудыг төвлөрүүлж ажиллах талаар НЗД-ын 2005 оны 108 дугаар захирамжийг хэрэгжүүлэн шинээр диспетчер-4, жолооч-7, засварчин-1\ ажилгүй байсан олон залуу боловсон хүчнээр ажлын байрыг нэмэгдүүлэн ажилласан.

Автобааз нь 2005 онд нийт 65 ажиллагсадтай, 57 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэй, 1082236,2 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй НЗД-ын 2004 оны 412 дугаар захирамжийн дагуу Тендер шалгаруулж суудлын "Хьюндэй Гранжир- ХГ", "Сонота-ЕF" машинуудыг худалдан авч, "Сонота-5" маркийн 01-72 УБЗ, 02-62 УБЗ, 06-22УБЗ авто машинуудыг балансаас балансад шилжүүлэн авч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон авто машинуудыг НӨХГазрын дуудлага худалдаагаар Уаз-фургон-3909, Кредос 04-13 УБЗ, Галлопер 02-67 УБЗ оруулсан. НЗД-ын 2005 оны 460 дугаар захирамжийн дагуу Хот орчноо гэрэлтүүлэх аяны хүрээнд байгууллагын дотор болон гадна гэрэлтүүлгийн ажлыг хийж 1836300 төгрөг зарцуулж, гадна гэрэлтүүлэг нь авто баазын байраас гадагш эргэн тойрондоо 20 м орчныг гэрэлтүүлэх хүчин чадалтай байна.

Авто бааз нь 2005 оны төлөвлөгөөний дагуу өөрсдийн хүч бололцоогоор диспетчер-механикийн байрыг тусад нь, халуун усны өрөө, бие засах газруудыг шинээр ашиглалтад орууллаа. Бензин шатахууны үнэ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа энэ үед өөрийн байгууллагын хашаан дотор бага оврын шатахуун түгээх станцыг суурилуулж, цаашид үнэ хямд шатахуун хэрэглэх боломжийг олгож байна.

Манай хамт олны хийсэн ажлын бүтээлийг Төр засаг, Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Нийслэлийн удирдах дээд байгууллагуудаас өндрөөр үнэлж Авто тээврийн байгууллагын 80 жилийн ойгоор авто баазын үйл ажиллагаа, хамт олны амжилтаас "Улаанбаатар таймс" сонинд материал гаргаж, ажилтан, албан хаагчид, жолооч нараас "Хөдөлмөрийн гавъяаны Улаан тугийн одон"-гоор жолооч Л.Доржпүрэв, "Алтан гадас" одонгоор инженер Д.Сундуйжав, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналаар Д.Баярсүрэн, Т.Халтар, Л.Доржпүрэв,

Я.Цогзолмаа, С.Бадрал нар, "Ахмад тээвэрчин" хүндэт үнэмлэхээр В.Жанчив, Б.Юра нар, "Онц тээвэрчин" цол тэмдгээр Г.Батчулуун, Ч.Батжаргал, Ш.Балсанжав, яамны Хүндэт жуух-аар Ж.Чулуунбаатар, Г.Баатар, М.Бямбадорж, "Осолгүй манлай цол" тэмдгээр жолооч Ц.Мөнх-Адъяа, М.Мөрөндэлгэр "Санхүү-банкны Тэргүүний ажилтан" цол тэмдгээр ня-бо Я.Эрдэнэцэцэг, яамны "Жуух бичиг"-ээр нярав Б.Саранпил, НХЗГ-ын "Шилдэг залуу" алтан медалиар жолооч Н.Энхбат, Х.Ганболд, О.Алдархишиг, НЗАА-ны шагналаар жолооч Ц.Түмэндэмбэрэл, О.Сүрэнхорлоо, Д.Цээрэгзэн болон бусад ажилчдыг харьяа байгууллагуудын шагналаар тус тус шагнасан байна.

2005 оны жилийн эцсийн тайлангийн хурлаар жилийн эцсийн ажлын үзүүлэлтээр Авто баазын "2005 оны Хөдөлмөрийн Аварга" жолоочоор Хүрэнбандийн Ганболд, Аваргын өргөмжлөл, сарын үндсэн цалингаар, жолооч Н.Гарамбат, Л.Доржпүрэв, Ч.Эрдэнэмөнх, М.Мөрөндэлгэр, Л.Баясгаланцогт, Ж.Чулуунбаатар нар удаах байруудад шалгарч шагнагдсан байна.

Санхүүгийн үйл ажиллагаа

2005 онд авто баазын санхүү нь төлөвлөсөн 21 төрлийг ажлыг хийж, холбогдох шимтгэл, тооцоог барагдуулан, 256089,0 мян.төгрөгийн орлого олж ажиллалаа.

Ажилчдын ар гэрийн нь амьдрал хүнд гачигдалтай, төрөл төрөгсөд нь нас барсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж, сувилуулсан ажилчдад 499,2 мян.төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгож сэтгэл санааны туслалцаа үзүүлж, Сар шинийн баяр, Ахмадын өдөр-өөр өндөрт настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн 600,0 мян.төгрөг, ажилчдын хүүхдүүдэд 294,6 мян.төгрөгийн бэлэг, Тээвэрчдийн баяр, хамт олны шинэ жилийг тэмдэглэн өнгөрүүлэхэд нийт 2207,5 мян.төгрөгийг зарцуулсан байна.

Хөмрөгийн түүх

Авто баазын архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төлөвлөсөн ажлуудыг гүйцэтгэж, дээд гарзаас ирсэн захирамжийн биелэлтийг НЗДТГазарт улирлаар гарган явуулж, гаднаас ирсэн бичиг, иргэд, ажилчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлүүлж, 2005 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 271, үүнээс байнга 57, түр хадгалах баримт 241, ББНШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 3, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 120 байна.

Байгууллагын дэргэдэх ББНШКомисс /комиссын дарга Д.Сундуйжав, нарийн бичгийн дарга Ч.Байгаль, гишүүдэд Я.Эрдэнэцэцэг, Х.Одончимэг, Б.Саранпил/-ын хурлаар хадгалах хугацаа дууссан 1993, 1999, 2000 оны баримтуудад нягтлан шалгалтыг хийж, төрийн архиваас зөвшөөрсний дагуу Устгах бичгийн түүвэр жагсаалт, акт үйлдэж 25 ширхэг хн-ийг устгалд оруулсан. НАГ-аас зохион

байгуулсан сургалтанд хамрагдаж байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч
Ч.Байгальд Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшлийн АХЛАХ зэрэг олгосон.

Түүхчилсэн лавлах бичсэн:
НЗДТГ-ын Авто баазын
Архив, бичиг хэргийн эрхлэгч

Ч.Байгаль,

25

Байгууллагын үйл ажиллагаа

Авто бааз нь 2006 онд 63 автомашин хөдлөх бүрэлдхүүнтэй, 71 ажилчин, албан хаагчидтай 1333352.0 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, Нийслэлийн Засаг даргын 2006 оны 02, 14 дүгээр захирамжийг хэрэгжүүлэн парк шинэчлэлтэд зориулж, "Автомашин худалдан авах, нийлүүлэх" Тендер шалгаруулж, хуваарилсан хөрөнгийн дагуу 10 ширхэг автомашин болон 4 автомашинд мотор агрегат худалдан авч, НЗД-ын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудад үйлчилж байгаа автомашинуудыг шинэчлэн, шинээр 6-7 ажлын байр гаргаж Нийслэлийн Засаг даргын 2005 оны 108 дугаар захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан НӨХГазраас Ниссан патрол маркийн 26-21 УБД, Чингэлтэй дүүргээс Ниссан патрол маркийн 01-59 УБЗ дугаарын автомашиныг балансаас балсансад шилжүүлэн авч, парк шинэчлэлтийг хийж ашиглалтын шаардлага хангахгүй болсон машинуудыг автобаазын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс НӨХГ-аас дуудлага худалдаагаар худалдах болон сэлбэгийн зориулалтаар ашиглуулах зөвшөөрөл авснаар Тоёото ЛН-51, Тоёото-Ландкрузер-80, Мицубуши-Делика маркийн автомашинуудыг сэлбэгийн зориулалтаар, Бенз-230 маркийн 2 автомашин, ниссан пикап маркийн 2, Паз-3205 маркийн автобус, Аксент маркийн автомашинуудыг тус тус дуудлага худалдаагаар худалдан борлуулсан

2006 онд автобаазын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар 15 ажлыг төлөвлөж, ажилтан, ажилчдад санамж, зөвлөмжийг харуулсан плакатуудыг байрлуулж, УМХГ болон НМХГ-ын хамтарсан шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар нилээд ажлыг зохиож, санал зөвлөлгөө өгсний дагуу Авто тээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн батлан гаргасан стандарт, дүрэм, журмуудыг автобаазын үйл ажиллагаанд мөрдөж ажиллан, Үйлчлүүлэгч байгууллагуудтай "Үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулж, 2006 оны Авто техникийн улсын үзлэгт амжилттай дүгнүүлж, автомашины оношлогоо, шилжилт хөдөлгөөн, үзлэгт шаардлагатай бүх сэлбэг, тослох материалыг бэлтгэж, автомашинуудад бүрэн засвар үйлчилгээг графикийн дагуу хийж парк ашиглалтыг 94 хувьтай ажиллуулж байна.

НИТХ-ын тогтоолоор 2006 оныг "Хороодын хөгжлийг дэмжих жил" болгосонтой холбогдуулан Налайх дүүргийн 3-р хороотой ажил төрлийн холбоотой ажиллаж, хорооны конторын халаалт, дулааны ажилд зориулан 1.0 сая /нэг сая/ төгрөгийн хандив, хорооны нэн ядуу болон эмзэг айл өрхүүдэд хувцас, эд материалын туслалцаа үзүүлж, хороонд шаардлагатай байгаа 2 компьютерийн асуудлыг шийдвэрлэж өгсөн.

Бензин шатахууны үнэ өдрөөс өдөрт нэмэгдсэнээр автобаазын санхүүгийн байдал нилээд хүндрэлтэй болсон үед Тээврийн үйлчилгээний тарифыг

нэмэгдүүлэх талаар НЗДаргын захирамжийг гаргуулан 2006 оны 11 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөн ажилласан байна.

ИХ МОНГОЛ улс байгуулагдсаны 800 жилийн ой, Монгол улсад Авто тээврийн байгууллага үүсч хөгжсөний 81 жилийн ой, Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 366 жилийн ойгоор улсад болон тээврийн салбар, автобаазад олон ажлын өндөр амжилт гарган, үр бүтээлтэй ажиллаж байгаа жолооч, ажилчдыг Төр засгийн одон медаль, Дээд газрын шагналуудаар шагнаж урамшууллаа. Үүнд :

"АЛТАН ГАДАС" одонгоор жолооч Н.Гарамбат, "ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-аар автобаазын дарга Ц.Батхуяг, жолооч Л.Баясгаланцогт, Ц.Түмэндэмбэрэл, ня-бо Я.Эрдэнэцэцэг, НИТХ-ын "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-өөр инженер Д.Сундуйжав, Ч.Байгаль, НИТХ-ын "ХҮНДЭТ ҮНЭМЛЭХ"-ээр жолооч М.Ганхуяг, Ц.Түмэндэмбэрэл, Г.Батчулуун, Нийслэлийн "ХҮНДЭТ ТЭМДЭГ"-ээр жолооч О.Сүрэнхорлоо, Т.Халтар, НЗД-ын "Жуух бичиг"-ээр диспетчер Х.Аюуш, жолооч Ц.Батборолзой, Х.Ганболд, ЗТАЖЯ-ны "АХМАД ТЭЭВЭРЧИН"-ээр жолооч Г.Баатар, Ж.Чулуунбаатар, "ОНЦ ТЭЭВЭРЧИН" цол тэмдгээр жолооч Ц.Мөнх-Адъяа, Д.Цээрэгзэн, ЗАА-ны "ӨРГӨМЖЛӨЛ"-өөр Д.Сундуйжав, Д.Цээрэгзэн, Ц.Түмэндэмбэрэл, "ИХ МОНГОЛ-800" жилийн ойн медалиар нийт 25 хүн, "ЧИНГИС ХААН" медалиар жолооч С.Пүрэвдорж, МАХН-ын "ХҮНДЭТ ТЭМДЭГ"-ээр жолооч Ж.Эрдэнэменх, НҮГ-ын БАЯРЫН БИЧИГ-ээр жолооч Б.Баатаржав, Б.Галаа, НХЗГ-ын "ШИЛДЭГ ЗАЛУУ" алтан медалиар Т.Саранчимэг, О.Ганзориг нар болон бусад ажилчид харьяа газрын болон автобаазын мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна.

Санхүүгийн үйл ажиллагаа

2006 онд санхүүгийн ажлын төлөвлөгөөг гаргаж 22 ажлыг хийж гүйцэтгэн, өр авлагатай газруудтай тооцоог хийж дуусган, ажилчдын цалинд 82712.7 мян.төгрөг, шатахуун, тослох материалд 148194.0 мян.төгрөг, сэлбэг, хэрэгсэлд 51403.4 мян.төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 15788.3 мян.төгрөг, цахилгаанд 2280.5 мян.төгрөг, телефонд 3652.5 мян.төгрөг, шагнал, урамшуулалд 512.4 мян.төгрөгийг зарцуулж 309092.2 мян.төгрөгийн орлого олж ажиллалаа.

Авто баазын санхүүгийн ажлыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн хүчин чадал сайтай компьютер 2-ийг авч, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн программыг суулгаж, санхүүгийн мэдээ тайланг цаг хугацаанд нь холбогдох газруудад явуулж, татварын болон нийгмийн даатгалын газартай тооцоог дуусгаж, Аудитын шалгалт, НМХГ-ын баримтын шалгалтанд өр төлбөр, дутагдалгүй шалгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 14 дүгээр тогтоолоор амьжиргааны доод түвшинг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ажилчдын цалинг нэмэгдүүлж, ажилчдын ахуй, амьдралыг дээшлүүлэх зорилгоор ХААН банктэй гэрээг шинэчлэн

38

хийж, нийт 8 ажилтанд цалингийн зээлийг олгож, амьдрал ахуйд нь тус боллоо. Автобаазын ажилчдаас ар гэрийн амьдрал нь хүнд гачигдалтай, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж сувилуулсан ажилчид, болон ах дүү төрөл, төрөгсөд нь нас барсан үед сэтгэл санааг нь хуваалцан 462.0 мян.төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон байна.

Байгууллагад ажиллаж байсан өндөр настнуудыг "Сар шинийн баяр", "Ахмадын өдөр"-өөр хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн 367.2 мян.төгрөг зарцуулан, сэтгэл санааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, ажиллаж байгаа Ахмад тээвэрчин 3 хүнд нутагтаа очих болон сувилуулахад нь 90.0 мян.төгрөгийн туслалцаа үзүүллээ.

Тэмдэглэлт ойн баяр, шинэ жил, Тээвэрчдийн баяраар автобаазын ажилчдын дунд спортын тэмцээн, уралдаан идэвхитэй амралтыг зохион байгуулж, амжилттай сайн ажилласан ажилчдыг шагнаж урамшуулахад 780.0 мян.төгрөг зарцуулж, ажилчдын хүүхдүүдийн судалгааг гаргаж, "Эх үрсийн баяр"-ыг тохиолдуулан 0-10 насны хүүхдүүдэд 200.0 мян.төгрөгийн бэлэг өгч урамшуулсан байна.

Хөмрөгийн түүх

Авто баазын архив, албан хэрэг хөтлөлтийг 2006 онд журам, стандартын дагуу гүйцэтгэж, Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу баримтуудыг хүлээн авч, байгууллагын архивыг цэгцэлж, архивын ажлын мэдээг НАГазарт явуулсан. Авто баазын БНШК-ын хурлаар хадгалах хугацаа дууссан баримтуудад нягтлан шалгалтыг хийж, хэлэлцэн төрийн архиваас зөвшөөрсний дагуу Устгах бичгийн түүвэр жагсаалт, акт үйлдэж 1992-1997 оны 35 ширхэг хн-ийг устгалд оруулсан.

2006 оны байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 271, үүнээс байнга 57, түр хадгалах хн-ийн тоо 214, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 62 болсон байна. МУ-ын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-н хүрээнд хэтийн төлөвлөгөө боловсруулж нилээд ажлуудыг үе шаттай хийхээр төлөвлөж, дараахи ажлуудыг хийж ажилласан.

1. Архивын өрөөг байгууллагын 2-р давхарт бичиг хэргийн өрөөнд тусгаарлагч хийж, архивын 2 сейф болон бусад хэрэгслүүдийг тавьсан.
2. НЗДТГ, МТГазартай хамтран байгууллагын компьютерүүдийг интернэтэд холбох ажлыг эхлүүлсэн байна.

Түүхчилсэн лавлах үйлдсэн:
НЗДТГ-ын Авто баазын
Архив, бичиг хэргийн эрхлэгч

Ч.Байгаль,

Байгууллагын үйл ажиллагаа

Авто бааз нь 2007 онд 58 автомашин хөдлөх бүрэлдхүүнтэй, 75 ажилчин, албан хаагчидтай 1305069.6 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажиллаж, НИТХ-ын тогтоол, НЗД-ын мөрийн хөтөлбөр, захирамж, Авто тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн батлан гаргасан стандарт, дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэглэгч, байгууллагуудад автомашинаар "Үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ"-ний дагуу соёлтой үйлчилгээг хүргэж, парк ашиглалтын коэффициентийг 94.0 хувьд хүргэж ажиллалаа.

2007 онд байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн ажлын төлөвлөгөөг жил, улирлаар гаргаж, төлөвлөсөн болон төлөвлөгөөнөөс гадна нийт 105 төрлийн ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж ирлээ.

НИТХ-ын тогтоолоор 2007 оныг "Дэд бүтцийг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлэх жил" болгосонтой холбогдуулан дараахи ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1. Байгууллагын орчин тойрны дэд бүтцийг сайжруулж тохижуулах ажлын хүрээнд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж авто баазын баруун талын 590 м2 зам талбайг шинээр засварлан, бетондож ажилд оруулан энэ ажилд 8378.0 мян.төгрөгийг зарцуулсан .

2. Ажлын байрыг нэмэгдүүлэх үүднээс Тоёото-ландкрузер маркийн 01-59УБЗ, Сонота-3 маркийн 03-27 УБЗ, Сонота-5 маркийн 07-61 УБЗ автомашинуудыг шинээр ажил үйлчилгээнд явуулж, мэргэжлийн засварчин, диспетчер-механик, жолооч, ажилчид нийт 12 ажиллагсдыг шинээр ажилд авч, ажлын байраар ханган ажилласан байна.

Нийслэлийн өмчит байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах зорилгоор НЗДТГазар болон НӨХГ-аас зохион явуулсан "Нийслэлийн нээлттэй өдөрлөг"-ажлын хэсэг байгуулагдан ажил үйлчилгээний онцлогийг тусгасан ажлуудыг хийж гүйцэтгэн , өдөрлөгт амжилттай оролцож, 2007-2008 оны өвөлжилтийн бэлтгэл ажил, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, урд ба хойд гараашийн дулаалга, галын бэлтгэл ажлууд, ажиллагсдын ажлын нөхцлийг сайжруулах зорилгоор бүх өрөөнүүдийн цонхыг вакуум цонхоор шинэчлэн сольж, дулааны узель, сантехникийн трубануудыг шинээр сольж, халуун усны бойлерийг шинэчлэн тавьж ажилд оруулсан .

2007 оны Авто техникийн улсын үзлэгт амжилттай дүн үзүүлж, байгууллагын бензин шатахууны зардлыг хэмнэх зорилгоор НЗД-ын 2007 оны 72 дугаар

захирамжийн дагуу Юнигаз ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, "Сонота" маркийн 32 автомашинд нефтийн шингэрүүлсэн хийгээр ажиллуулах төхөөрөмжийг суурилуулан "газ"-ийг хэрэглэж ажилласнаар шатахууны зардлыг 10 хувиар хэмнэж ажиллалаа.

Автобаазын парк ашиглалтыг сайжруулах зорилгоор зарим машинуудад ховор сэлбэг хэрэгслийг захиалан авчирч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон машинуудыг автобаазын Өмч хамгаалах байнгын зөвлөл НӨХГ-аас дуудлага худалдаагаар худалдах болон сэлбэгийн зориулалтаар ашиглуулах зөвшөөрөл авсны дагуу 03-27УБЗ, 02-29УБЗ, 02-81УБЗ дугаарын автомашинуудыг сэлбэгийн зориулалтаар, "Элантра" маркийн болон "Тоёото-кариб" маркийн автомашинуудыг тус тус дуудлага худалдаагаар худалдан борлуулсны орлогоор автомашины сэлбэг, шатах тослох материалын нөөцийг бий болгон ажилласан байна.

Санхүүгийн үйл ажиллагаа :

2007 онд санхүүгийн ажлын төлөвлөгөөг гаргаж 20 ажлыг хийж гүйцэтгэн, өр авлагатай газруудтай тооцоог хийж дуусган, ажилчдын цалинд 97042,4 мян.төгрөг, шатахуун, тослох материалд 143372,5 мян.төгрөг, аж ахуйн материалд 11557,2 мян.төгрөг, сэлбэг хэрэгсэлд 58239,1 мян.төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 18617,9 мян.төгрөг, дулаан, цэвэр, бохир усанд 4643,6 мян.төгрөг, цахилгаанд 2195,3 мян.төгрөг, телефонд 3847,4 мян.төгрөг, шагнал, урамшуулалд 1283,6 мян.төгрөгийг зарцуулж 362547,5 мян.төгрөгийн орлого олж ажиллалаа.

НЗД-ын мөрийн хөтөлбөрийн дагуу "Цахим-Улаанбаатар" нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Санхүүгийн ажилтнуудын компьютерийг дотоод сүлжээнд холбож, диспетчерийн бүртгэлийг компьютерт оруулснаар жолооч нарын явсан км, спидометрийн заалт, автомашинуудад хэрэглэж байгаа бензин, шатахуун, тослох материал, сэлбэг хэрэгслийн болон аж ахуйн эд материалын орлого, зарлагын тооцоо, үлдэгдлийг оруулснаар түргэн хугацаанд байгууллагын санхүүгийн мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх боломжтой болж, Нийслэлийн Аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын шалгалтанд өр төлбөргүй шалгууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 13, 237 дугаар тогтоолоор тус тус Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалтнуудын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан ажилчдын цалинг 15-25 хувиар нэмэгдүүлж, 7 ажилтанд цалингийн зээлийг олгож, амьдрал ахуйд нь тус болж, ар гэрийн амьдрал нь хүнд гачигдалтай, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж сувилуулсан ажилчид, болон ах дүү төрөл, төрөгсөд нь нас барсан үед сэтгэл санааг нь хуваалцан 1238,2 мян.төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон байна.

31

Байгууллагад ажиллаж байсан өндөр настнуудыг "Сар шинийн баяр", "Ахмадын өдөр"-өөр хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн 334,7 мян.төгрөг зарцуулан, сэтгэл санааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, ажиллаж байгаа Ахмад тээвэрчин 1 хүнд нутагтаа очих болон сувилуулахад нь 30.0 мян.төгрөгийн туслалцаа үзүүллээ.

Ардын Их хувьсгалын 86 жил, Монгол улсад Авто тээврийн байгууллага үүсч хөгжсөний 82 жилийн ой, Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 367 жилийн ойгоор улсад болон төрийн үйлчилгээний салбар, автобаазад олон ажлын өндөр амжилт гарган, үр бүтээлтэй ажиллаж байгаа жолооч, ажилчдыг Төр засгийн одон медаль, Дээд газрын шагналуудаар шагнаж урамшууллаа. Үүнд :

"ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-аар авто баазын жолооч Т.Халтар, Х.Ганболд, М.Ганхуяг, нярав Б.Саранпил, диспетчер-механик Я.Цогзолмаа, архив-бичиг хэргийн эрхлэгч Ч.Байгаль, НИТХ-ын "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-өөр жолооч Н.Гарамбат, В.Жанчив, НИТХ-ын "ХҮНДЭТ ҮНЭМЛЭХ"-ээр жолооч Ч.Эрдэнэмөнх, А.Нэргүйбаатар, Ц.Түмэндэмбэрэл, диспетчер-механик Б.Нямсүрэн, Нийслэлийн "ХҮНДЭТ ТЭМДЭГ"-ээр жолооч Г.Батчулуун, Б.Юра, НЗД-ын "Жуух бичиг"-ээр тооцооны ня-бо Х.Одончимэг, жолооч Г.Баатар, ЗАА-ны "Баярын бичиг"-ээр С.Пүрэвдорж, Э.Энх-Амар, НҮГ-ын "Баярын бичиг"-ээр жолооч Б.Юра, диспетчер-механик Г.Тунсаг, НХЗГ-ын "ШИЛДЭГ ЗАЛУУ" алтан медалиар жолооч Х.Батболд О.Мөнхбат, Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын "Өргөмжлөл"-өөр Г.Алтан-Оч, Б.Ганзориг, З.Очирпүрэв, Баянзүрх дүүргийн шагналаар А.Цэлмэн, НЗДТГ-ын Цэргийн хэлтсийн шагналаар Л.Баясгаланцогт нар болон бусад ажилчид харьяа газрын болон авто баазын мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна.

Хөмрөгийн түүх

Нийслэлийн төр захиргааны авто баазын даргын 2007 оны 54 дүгээр тушаалаар ББНШКомисс шинэчлэгдэж, комиссын даргаар Д.Сундуйжав /Ерөнхий инженер/, гишүүдэд Я.Эрдэнэцэцэг /Ерөнхий ня-бо/, Х.Одончимэг /тооцооны ня-бо/, нарийн бичгийн даргаар Ч.Байгаль /архив, бичиг хэргийн эрхлэгч/ нар томилогдож, байгууллагын архивын үйл ажиллагааг МУ-ын "Архивын тухай хууль", Засгийн газрын 1995 оны 53 дугаар тогтоол, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалын дагуу "Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам", байгууллагын "Архивт баримт хүлээн авах журам"-уудыг шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын жилийн болон архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг гүйцэтгэж, дээд гарзаас ирсэн захирамжийн биелэлтийг улирлаар

гарган явуулж, гаднаас ирсэн бичиг, иргэд, ажилчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлүүлсэн.

2007 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 293, үүнээс байнга 76, түр хадгалах баримт 217, НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 3, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 51, лавлагаа хуулбар 17-г олгож, байгууллагын ББНШК-ын хурлаар хадгалах хугацаа дууссан 1997-2001 оны баримтуудад нягтлан шалгалтыг хийж, төрийн архиваас зөвшөөрсний дагуу Устгах хэргийн акт №6 үйлдэж нийт 38 ширхэг хн-ийг устгалд оруулсан.

МУ-ын Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-н хүрээнд хэтийн төлөвлөгөө боловсруулж нилээд ажлуудыг үе шаттай хийхээр төлөвлөсний дотор :

1. Албан хэрэг хөтлөлтийн ажилд одоо ашиглаж байгаа компьютерийг шинэчлэн солих хөрөнгө мөнгөний бололцоогүй тул эхний удаад CD-RAM ажиллагаатай санхүүгийн ажилд хэрэглэж байсан процессороор сольж, санхүүд нэг шинэ компьютер авч тавьсан.
2. НЗД-ын 2007 оны 329 дугаар захирамжаар Байгууллагын нэр өөрчлөгдөж **Нийслэлийн төр захиргааны авто бааз** болсонтой холбогдуулан, авто бааз УҮГ-ын дүрмийг шинэчлэн боловсруулан, баталгаажуулж, тамга тэмдэг, гэрчилгээ, хэвлэмэл хуудас, гадаах хаягийг шинээр өөрчлөн сольсон.
3. НЗД-ын 2007 оны 414 дүгээр захирамж, Үндэсний Архивын газрын "Төрийн ба төрийн бус байгууллагын архивын баримтанд тооллого явуулах ажлын удирдамж"-ын дагуу ББНШКомисс байгууллагын архивын баримтанд ээлжит тооллогыг хийж, байнга хадгалах 66 хн, түр хадгалах 216 хн, нийт 282 ширхэг хадгаламжийн нэгжийг тоолж, баталгаажуулсан.
4. МУ-ын Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн салбар зөвлөлөөс явуулсан "Төрийн албан хаагчдын тооллого"-д нийт 63 ажиллагсдыг хамруулж тоолуулснаар ажиллагсдын мэргэжлийн бичиг баримтыг баталгаажуулж, хувийн хэргийн баяжилтыг хийсэн.

***Түүхчилсэн лавлах үйлдсэн: Нийслэлийн төр захиргааны
Авто баазын архив, бичиг хэргийн эрхлэгч Ч.Байгаль***

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ
2008 он.

1. Байгууллагын үйл ажиллагаа

Авто бааз нь 2008 онд 69 автомашин хөдлөх бүрэлдхүүнтэй, 67 ажилчин, албан хаагчидтай 1178996,6 мян.төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажиллаж , НИТХ-ын тогтоол, НЗД-ын мөрийн хөтөлбөр, захирамж, Авто тээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн батлан гаргасан байгууллагын, дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэглэгч, байгууллагуудад соёлтой үйлчилгээг хүргэн, нийслэл хотынхоо хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

МУ-ын Засгийн газрын тогтоолоор 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгосонтой холбогдуулан “Эрүүл хүнс-Эрүүл орчин” аяны хүрээнд дараахи ажлуудыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

1/ Байгууллагын ажилчдын цайны газрын хоол, хүнсэнд чанарлаг бүтээгдэхүүн илүү хэрэглэх, аарц, цагаан идээ, сүүн бүтээгдэхүүнээр үйлчилсэн.

2/ Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс Нийслэлийн Өмчийн харилцааны газраас зөвшөөрөл авсны үндсэн дээр ажилдын “Амралт-чийрэгжүүлэлтийн өрөө”-г засварлан тохижуулж, иж бүрэн теннисний ширээ, сандлыг тавьж, энэ ажилд 4,0 сая төгрөгийг зарцуулж, эрүүл ажиллах орчинг бүрдүүлж байгууллагын баруун талтын замыг тохижуулж, 18-20 ширхэг мод тарьж ургуулах ажилд ажиллагсдыг хамруулан ажиллалаа.

МУ-ын Засгийн газрын 2007 оны 349-р тогтоолын дагуу хотын дотор том оврын жип автомашиныг цөөрүүлэхтэй холбогдуулан, НЗД-ын 2008 оны 45 дугаар захирамжийн дагуу жип автомашинуудын судалгааг гаргаж, нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд, харьяа газруудын жип автомашинуудыг төвлөрүүлэн авч, Техникийн комиссын акт, дүгнэлт гаргаж, НӨХГ-тай хамтран дуудлага худалдаанд оруулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Байгууллагын бензин шатахууны зардлыг хэмнэх зорилгоор НЗД-ын 2007 оны 636 дугаар захирамжийн дагуу бензин шатахуун бага зарцуулдаг суудлын автомашиныг Тендрээр шалгаруулж “Ди ди Эл” ХХК-аас Хьүндэй Верна-Аксент маркийн 9 автомашинаар парк шинэчлэлтийг хийж, Хотын ерөнхий менежерийн албан үйлчилгээнд Тоёото-Камри автомашиныг шинээр, Нийслэлийн ЗАА-аас дунд оврын Ниссан Сибиран маркийн дунд оврын автобусыг балансаас балансад шилжүүлэн авч, парк ашиглалт техникийн үйлчилгээг сайжруулан ажилласан.

Жолооч нарын дунд хотын хөдөлгөөний шинэчилсэн дүрмээр шалгалт авч, нийт 44 жолоочоос 31 жолооч хамрагдаж, цаашид жолооч нарт зааварчилгаа, санамж өгч, хэрэглэгч үйлчлүүлэгч 29 байгууллагуудаас ажил үйлчилгээний талаар санал, асуулга авч, Төрийн үйлчилгээний соёл, харьцаанд илүү анхаарах, ажилчдын нийгмийн асуудлаар гэр хүссэн жолооч, ажилчдын хүсэлтийг НЗД-ын орлогч даргад хүргүүлж, Нийслэлийн 369 жилийн ойгоор 5 жолоочид гэр олгуулсан.

2. Санхүүгийн үйл ажиллагаа

2008 онд ажилчдын цалинд 136297,4 мян.төгрөг, шатахуун тослох материалд 161545,7 мян.төгрөг, сэлбэг хэрэгсэлд 48459,4 мян.төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 15003,1 мян.төгрөгийг зарцуулж, 418431,8 мян.төгрөгийн орлого олж ажилласан байна. Бензин шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан санхүүгийн өнөөгийн байдлын талаар тооцоо, судалгааг хийж, холбогдох дээд газруудад танилцуулснаар НЗД-ын 2008 оны 583 дугаар захирамжаар авто баазыг “Улсын төсөвт үйлдвэрийн газар”-ын ангилалд хамруулан бүтэц, орон тоог шинэчлэн баталсан нь ажилтан, албан хаагчид маань Төрийн үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийн цалинг авах боломжийг бүрдүүлж өгсөн.

3. Хөмрөгийн түүх

Байгууллагын жилийн болон архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг гүйцэтгэж, дээд гарзаас ирсэн захирамжийн биелэлтийг улирлаар гарган явуулж, гаднаас ирсэн бичиг, иргэд, ажилчдаас ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлүүлж, 2008 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн нэгжийн тоо 352, үүнээс байнга 93, түр хадгалах баримт 239, НШАЗК-ын хурлаар батлагдсан дансны тоо 3, түр хугацаатай ашиглуулсан хн-ийн тоо 100, лавлагаа хуулбар 17-г олгож, байгууллагын ББНШК-ын хурлаар Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчилж, батлуулан мөрдөн ажиллаж байна.

Архивын байгууллага үүсч хөгжсөний 80 жил, “Архивчдын өдөр”-ийг угтсан төлөвлөгөөт ажлууд, сургалт, семинарт хамрагдаж, архив, бичиг хэргийн эрхлэгчийг НАГ-ын төлөвлөгөөт сургалтын дагуу БНХАУ-ын Хөх хот, Эрээн хотуудын архивын байгууллагуудтай танилцуулж, НАГ-тай “Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан ажилласан. “Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 10-аад ажлыг хийж, байгууллагын “Эрхэм зорилго”-ыг самбарт байрлуулж, гадаах хаягийг шинээр сольж, тохижуулсан.

*Түүхчилсэн лавлах үйлдсэн: Нийслэлийн төр захиргааны
Авто баазын архив, бичиг хэргийн эрхлэгч Ч.Байгаль*

9/9-5

38

Нийслэлийн Авто замын газар

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

Улаанбаатар хот

2009 он

1/1 X 2

Нийслэл хотын авто замын салбарын түүхэн хөгжлөөс

1921 онд ялсан Ардын хувьсгалын өмнө Монгол оронд ердийн хөсгийн зөрөг замаас өөр засмалгүй, 10-дхан ширхэг модон гүүр байсны 6 нь Нийслэл хүрээнд, хоёр нь хүрээний орчимд Туул голд баригдсан байв. 1922 оны 4-р сарын 14-нд хуралдсан Засгийн газрын хуралдаанаас тогтоол гаргаж Нийслэл хүрээнээс гарах 3 замыг засуулах, зүүн ба баруун урд Туул голд тавьсан гүүрүүд элэгдэн хуучирсан учир сэлбэн засуулах, бас Хүрээ, Хиагтын хооронд перевоз бэлтгэж элдэв алба амины хэргийг саатуулахгүй болгохыг Сангийн ямаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж байжээ. 1923 оны 7-р сард нийтлэгдсэн “Эдийн засгийн үндсэн бодлого” гэсэн баримт бичигт “.....эдийн засгийг ард түмэнд тустай сайнаар явуулсугай хэмээвээс арга буюу олон газрын нэвтрэлцэх хэргийг хүндэтгэн үзэж муу замыг сайн болгох, гүүргүйд гүүр, онгоц зэргийг байгуулах..... ” гэх зэргээр замын асуудлыг онцгойлон авч үзэж байсан байна.

Мөн 1924 онд хуралдсан Улсын Анхдугаар Их хуралд Дотоод яамнаас оруулсан илтгэлд “Хотын доторхи авто замыг тэгшлэн засаж шулуун болгохыг оролдон буй.....” гэжээ.

1924 оны 10 сарын 29-нд Улсын Анхдугаар Их хурлаас Нийслэл хүрээг Улаанбаатар гэж нэрлээд 1925 онд хотын захиргааны шинэ дүрэм баталж, түүнийхээ дагуу хот орчныг сайжруулах, хөгжүүлэх нийт хотын хороо ангийг шинэчлэн зохион байгуулах, түүнийг удирдах ажилд хотын хөдөлмөрчдийг өргөн оролцуулах, хотын хуучин зургийг байгаагаар нь гаргаж зам гудамжуудыг тэгшлэн засах, хог бүртгийг ариутган цэвэрлэх, хашаа хаалгуудыг дэс дараалсан дугаартай болгож цэгцлэх, хотын харъяат ардууд гэж хэн болох ямар үндсэн дээр бүртгэн батлах зэрэг ажлуудыг идэвхитэйгээр үүсгэн зохиох эхэлжээ. Энэ үед хотын дотор хааны музейн чиглэлд Дунд голын ногоон гүүр, Консулын дэнжийн чиглэлд Сэлбийн модон гүүр, Зүүн хүрээнд Сэлбэ гол дээрх Жадрын аймгийн Улаан гүүр г.м хэдэн гүүр сэлбэн засаж заримыг шинээр барих ажил эхэлжээ. 1924 оны үед Багшийн сургууль, Монгол банк, Хэвлэх үйлдвэр, “Ленин” клуб зэрэг барилгууд эхний ээлжинд баригдаж хотын гудамж зээлийг тохижуулжээ. 1925 онд “Туул” рестораны урд хэсэгт 100 гаруй метр урт газар чулуун зам засжээ.

1929-1933 онуудад хотод Яармаг, Сонгино, Налайх зэрэг газруудад зам гүүрийн засварт 600 мян.төг зарцуулж байжээ.

1932 онд төвийн зам ангийг байгуулан даргаар нь Гомбодорж, инженерээр Кузменцов нарыг томилон ажиллуулжээ. Зөвлөлтийн мэргэжилтэн гүүрийн мастер Черноковын бригад орос мужаан 16, бусад орос монгол нийлсэн 30 гаруй ажилчид чиргүүлтэй 2 авто машин багаж хэрэгсэл, орон сууцны бусад аж ахуйн зүйлийг бүрдэл болгон 4-р сараас ажилд оруулж хот орчны зам, Баянзүрхийн гүүрийн шинэ барилга, Сэлбийн гүүрийн засвар, Налайх, Сонгино чиглэлийн зам засварын ажлыг хариуцан ажиллажээ.

1934-1935 онд Аж үйлдвэрийн комбинат ашиглалтанд орсноос хойш УБ-Налайх хоорондын тээвэр их нэмэгдэж зам засварын ажлыг хотод тогтмол хийж байх шаардлагатай болжээ.

1935 оны 11-р сарын 25-ны СнЗ-ийн хурлаар УБ хотыг хөгжүүлэх өргөн бүрэлдэхүүнтэй комисс томилогдсон бөгөөд тус комисс нь хотын гол гудамж замуудыг засч сайжруулах, гудамжуудыг гэрэлтүүлэх зэрэг ажлуудыг эрчимтэй хийх болжээ.

1936 оны 10-р сард багтааж хотын зураг төлөвлөгөөг шинээр боловсруулах инженерийн групп байгуулж хотыг нэгдмэл зураг төлөвлөгөөтэй хөгжүүлэх анхны төслийг гаргаж, шинээр барих барилга, зам гудамж талбайнуудыг нарийн төлөвлөж 4,2 км кв газрыг хамарсан зүүн Сэлбээс баруун тийш хотын төв хэсгийг оруулан Сүхбаатарын нэрэмжит талбайг хотын төв хэсэг болгохоор үзэж талбайн өмнө захыг дайруулан, зүүн захыг Консулын дэнжээс эхлэн баруун зах хүртэл замыг хотын төв гудамж болгохоор үндэслэн бодож түүнд тохиолдох хуучин том жижиг 34 тооны нарийн тахир гудамжуудыг шулуун болгож засахаар хамруулан төлөвлөж төв талбайд Засгийн газрын барилга, улсын төв театр, дотоод яамны орон сууц, холбооны яамны барилга, бусад үйлдвэр, соёлын барилгуудыг барих, төв талбайгаас Туул гол, Богд уулын ам хүртэл зам гүүр, гудамж талбай барихаар төлөвлөжээ. Энэ анхны төлөвлөгөө нэлээд өөрчлөгдсөн боловч хотыг төлөвлөгөөтэй хөгжүүлэх үндсийг зөв тавьж өгчээ. Тэр төлөвлөгөөний үндсэн дээр Нийслэл хотыг шинэчлэн сайжруулах ажил 1937-1939 онд Сүхбаатарын чөлөөний өмнүүр үргэлжилсэн өргөн засмал замыг барьж төв гудамж болгон тохижуулах ажлаар эхэлсэн байна. Улаанбаатар-Алтанбулагийн хооронд ЗХУ-ын хүч

хөрөнгөөр 349 км 672 у/м засмал зам тавигдсан бөгөөд үүний эхний 0.0 цэг одоогийн Офицеруудын ордны орчимоос эхэлсэн бөгөөд УБ хотын төвөөр дайрсан 5.86 км урттай 12 м өргөн шороон далантай, 10 м өргөн 16 см зузаан хайрган суурь, 12 см зузаан гүн нэвтэлгээний аргаар хар буталсан чулуун хучилттайгаар барьсан нь 1957 он хүртэл ашиглагдаж байжээ. 1938-1939 онд энэ зам баригдсанаар УБ хот хатуу хучилттай хар замтай болж "Хувьсгалын зам" хэмээн нэрлэжээ.

СНЗ-ийн 1939 оны 32-р тогтоолоор Нийслэл хотын төв хэсгийн 113 гудамжны нэрийг шинэчлэн тогтоож байв.

Дайны дараа жилээс нам засгаас замын барилга байгуулалтын ажилд онцгой анхаарч УБ-ын орчимд цардмал зам талбай засах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, техник нэвтрүүлэх, зураг төслийг өөрсдөө хийх, Авто замын газрыг бэхжүүлэх зорилт тавьж 1946 оноос С.Лувсанчүлтэм гуайг замын газрын даргаар ажиллуулжээ. 1948-1950-иад оны дунд үед Их сургуулийн гудамжны авто зам, Яармагийн зам, НТХ-ын хуучин барилгын /одоогийн МАХН-ын байр байгаа газар/ үүдний талбай, Хуучин их дэлгүүр, Улсын банкны арын гудамж, Сүхбаатарын гудамж болон Гадаад яамны баруун талын Их тэнгэрийн ам Чойбалсангийн зуны байр хүртэл цардмал зам, Их тэнгэрийн амны Туул голын модон гүүр зэргийг барьжээ. УБ хотод хамгийн анхны гудамжны гэрэлтүүлэг "Хувьсгалын зам"-ын гудамжинд тавигдсан байна.

1956-1960 онуудад УБ хотод ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжаар 1,2-р 40000-тын орон сууцны барилгууд, БНХАУ-ын буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр гудамж зам, гүүрүүд баригдаж хотод шинэ өргөн гудамж талбай, орон сууцны хорооллууд бий болов.

БНМАУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1956 оны хэлэлцээрээр Хятадын зам барилгын 566-р анги Нүхтийн 6195.83 м, Зайсангийн амны 1914.37 м, Баянзүрхийн 8013 м урт гүн нэвтэлгээний хар замуудыг барьж 1957 оны оны 9-р сард Хятадын . гүүр барилгын 564-р анги Энхтайваны 377.1 м, Баянзүрхийн /Туул голын/ 175.5 м төмөр бетон гүүрүүдийг барьж 1958 оны 9-р сард ашиглалтад өгөв. Мөн Туул голын Яармагт 183.4 м төмөр бетон гүүрийг барьж 1959 онд өгчээ. Үүний зэрэгцээгээр хотын доторх гол гудамжууд болох :

- Энхтайваны зүүн /Төв шуудангаас –Офицеруудын ордон/

- Офицеруудын ордон-Чулуун овоо хүртэлх
- Энхтайваны баруун /Төв шуудангаас-Төмөр замын техникум/
- Бага тойрог
- Их тойрог /урд/ ТТБаазаас -Чулуун овоо хүртэл
- Ленины өргөн чөлөө /Сталины номын сангаас-Комбинатын цагаан хаалга/
- Найрамдлын зүүн хэсэг /Бага тойрог-Польш элчин/
- Найрамдлын зүүн хэсэг /Бага тойргоос- Их тойрог/
- Нэгдсэн үндэстний гудамж
- Октябрийн гудамж /Туул ресторан-Их тойрог/ зэрэг бүгд 29 км 924.75 м гүн хар хучилттай замуудыг барьж 1960 оны 10-р сарын 27-нд ашиглалтанд өгснөөр УБ хотын төв хэсэг үндсэндээ өргөн дардан гудамж замтай болжээ.

Эдгээр гудамжууд нь бүгд 2 талаараа явган хүний замтай, олонхи гудамжууд нь 9404,6 у/м борооны ус зайлуулах далд хоолойтой, хотын гаднах гэгдэх Нүхт, Зайсан, Баянзүрхийн 16123,2 м замууд нь 6 ширхэг жижиг гүүр, 7 ш хоолойтой баригдсан юм.

Энхтайваны зүүн хэсгийн урд салаа- 1859 м, Их дэлгүүрийн зүүн зам- 366,0 м, Их дэлгүүрийн урдах хос зам- 246,0 м, Тамирчдын буюу Шмералийн гудамж- 328,0 м, Толгойтын зам- 6331 м, Энхтайваны гүүрийн урд зам- 1289 м, Төв паркийн доторхи- 2010 м гэх мэт бүгд 12 км 429 м гудамж замыг 1961 оны 7-р сарын 27-нд ашиглалтанд оруулжээ. Найрамдлын зүүн /Польш элчингээс зүүн тийш/- 640 м, Марксын гудамжны /Их тэнгэрийн гүүр хүртэл/- 3214,46 м, Нэгдсэн үндэстний гудамжны баруун, зүүн- 680,04 м, Сталины гудамж /1 арван жилийн сургуулийн өмнөх/- 2247,77 м, 2-р төрөхийн зүүн- 246,37 м, Гандангийн тойрог зам- 831,99 м зэрэг 7860,63 м гудамж замууд 1962 оны 10-р сарын 8-нд, Найрамдлын хаалганаас хойш дунд гол- 967,5 м, 11-р сургуулийн зүүн- 223,7 м, Гандангийн хүүхдийн больницийн өмнөх- 1029,96 м, Их сургуулиас 3 буудал- 679 м зэрэг 2900,16 м урт гудамж замууд 1963 онд, Марксын гудамжны үргэлжлэл- 157 м, Мебелийн фабрикийн зүүн зам- 309,4 м, Гандангийн урд зам- 736,7 м, Сүхбаатарын гудамжны хойт үргэлжлэл- 386 м зэрэг бүгд 2326,1 м гудамж замууд 1964 онд ашиглалтанд оржээ. Их дэлгүүрийн зүүн 12-р зам- 462 м, Хүүхдийн больницийн баруун өмнөх уулзвар- 467 м, 30, 32, 29, 34-р замууд бүгд 2797,08 м зам 1965 оны

9-р сарын 15-нд, Гандангийн 25-р зам, Сүүн заводын 36-р зам, Вокзалийн 37-р зам зэрэг 2415 м зам 1966 оны 9-р сарын 15-нд ашиглалтанд орсон юм.

СнЗ-ийн 1956 оны 288-р тогтоолоор Авто замын барилга, засвар ашиглалтын ажлыг авто тээврийн гол чиглэл үйл ажиллагаатай нягт уялдуулан явуулах зорилгоор ДЯЯ-ны Замын хэрэг эрхлэх ерөнхий газрыг Тээврийн яаманд шилжүүлж орон нутгийн зам ангиудын удирдлагыг нийслэл хот, аймгийн гүйцэтгэх захиргаанд өгсөн байна. Энэ тогтоолоор хотын зам ашиглалтын дистанцыг УБ хотын гүйцэтгэх захиргаанд харьяалуулав.

УБ хотын төв болон түүний дүүрэгт 1957-1966 онуудад БНХАУ-ын тусламжаар бүгд 111,8 км буюу хотын дотор 60,67 км, хотын гадна 51,12 км гудамж зам, 216,3 км явган хүний зам, 15,6 км урт борооны ус зайлуулах хоолой, 55800 м2 талбай 3 ш том төмөр бетон гүүр, 19 ш дунд ба жижиг төмөр бетон гүүр, 95 ш хоолой баригдаж ашиглалтад орсон юм. Ингэснээр УБ хотын модон гүүрүүд шинэчлэгдэж Туул голын Баянзүрх, Яармаг, Дунд гол, Энхтайваны том төмөр бетон гүүрүүд, Сэлбэ, Арслантай, Сэлбийн дээд /Их тойргийн/, дунд /Чингис зочид буудлын арын/, доод /Замын цагдаагийн зүүн/, Дунд голын /Металлистын ТМС-ын арын/ зэрэг 50-60 м урттай дунд хэмжээний төмөр бетон гүүрүүдтэй болж гол гудамж замууд, 2 талаараа явган хүний замтай, мод зүлэгтэй, гэрлэн дохиололтой болж тохьжив.

Хотод гудамж, зам, гүүр, явган зам, бороо усны хоолой худаг баригдаж засвар арчлалтын ажил өргөжсөнтэй холбогдуулан СнЗ-ийн 1961 оны 3-р сарын 3-ны 203-р тогтоолоор "Улаанбаатар хотын доторх зам, гүүр гудамж талбайн засвар үйлчилгээг хариуцах" зам ашиглалтын ангийг 2 дистанцтайгаар, мөн барилга байгуулалт зам талбайн тохижуулалтын ангийг 1961 оны 5-р сарын 20-оос Замын хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулж СнЗ-ийн 1962 оны 4-р сарын 11-ний 178-р тогтоолоор УБ хотын АДХГЗ-нд шилжүүлжээ. Энэ ангийг СнЗ-ийн 1972 оны 12-р сарын 8-ны 474-р тогтоолоор "УБ хотын зам, далан суваг ашиглалтын контор" болгон өргөтгөсөн. Уг конторыг СнЗ-ийн 1975 оны 253-р тогтоолоор ББМҮЯ-ны ЗГБТрестийн төвийн зам ангитай нэгтгэж УБ хотын Зам барилга, ашиглалтын контор болгожээ. СнЗ-ийн 1964 оны 103-р тогтоолоор УБ хотын зам барилгын конторыг өргөтгөсөн бөгөөд түүний харъяанд байгуулагдсан Гүүрийн барилгын анги Туул голын Зайсанд анхныхаа төмөр бетон гүүрийг өөрсдийн инженерүүдийн

хийсэн зураг төслөөр 1965 оноос барьж 1969 онд ашиглалтанд оруулжээ. Зөвлөлтийн гүүрийн барилгачид 1966-1967 онд Туул голын Баянзүрх, Яармагийн төмөр бетон гүүрийг засаж тус бүрийг 3 алгаслаар уртасгаж, Улиастайн голд 98 м төмөр бетон гүүрийг шинээр барив. Мөн түүний үргэлжлэл болгон үерт урссан Сонсголонгийн модон гүүрийн оронд 295 м урт төмөр бетон гүүрийг Нисэхийн замаас Толгойтын зам хүртэлх 5 км бетон замын хамтаар барьж 1971 онд Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор манай улсад бэлэг болгон хүлээлгэж өгчээ. 1968 онд Замын хэрэг эрхлэх газрыг татан буулгаж ББМҮЯ-ны харьяанд Зам гүүрийн барилгын трестийг байгуулж шинээр байгуулагдсан Тээврийн яаманд замын ашиглалт, захиалагчийн үүргийг хариуцуулжээ. Ингээд Тээврийн яамны захиалгаар ЗГБТрест Их тэнгэрийн чиглэлийн 60 у/м төмөр бетон гүүр, 7 буудлаас Шаргаморьт хүртэлх Хятадын замчдын дутуу орхисон 10 км зам, Нисэх-Биокомбинатын 7,1 км асфальтобутон замууд, Улаанхуаран, Бага тойрог, Их тэнгэр, Зайсангийн хооронд болон Яармаг, Толгойт чиглэлд хар зам, Тэрэлжийн 2 даваанд 7,8 км хайрган болон барилгын орчны тохижилтын ажил хийжээ.

1969 онд Авто замын байгууллагын 40 жилийн ойг тэмдэглэв. Энэ үеэр Нийслэлийн зам гүүрийн өсөлтийн судалгааг гаргасан байна. Үүнд: Автын цардмал зам- 1194985 м², Хайрга, хөрсөн зам- 59,5 км /416400м²/, явган цардмал зам- 74,1 км /217643 м²/, Цардмал талбай- 145608 м², Төмөр бутон гүүр, труба 151 ш /1788 у/м/, Модон гүүр, труба 30 ш /901 у/м/, Ус зайлуулах хоолой систем- 15028 у/м, Замын бусад аж ахуйн өртөг 2281023 төг байжээ.

1971 онд Их тэнгэр Зайсанг холбосон 2,2 км зам, 1972 онд Нисэхээс Биокомбинат чиглэд 6 км зам, 1973 онд Зайсангийн больниц хүртэл 2,7 км, Шаргаморьт чиглэлд 5,4 км асфальтобетон замууд баригдав. 1974 онд төмөр замын хорооллоос Толгойт хүртэлх хар замын дэргэдүүр 2 дахь зам барих ажил хэлж 7 м өргөн зорчих хэсэгтэй, 5,3 км урт өндөрлөсөн замыг барьж 10 сарын 31-нд ашиглалтанд оруулжээ. Энэ жил ЗГБТ-ийнхэн Яармагийн гүүр, Толгойтын хооронд /ТЭЦ-III-ын арын/ 68 м урт төмөр бетон, 1,6 км авто замтай хамт барив.

1975 онд Толгойтын замаас Тоосгон завод хүртэлх 3,5 км, Зурагт чиглэлд 0,8 км, 1976-1979 онуудад Баянхошууны 3,2 км, Шархадны 1,8 км, Баянголын ОУПЗуслангийн 14,3 км, Чингэлтэйн 2,1 км, Хайлаастын 1,9 км, Баруун нарангийн

1,9 км зам баригдаж, Налайхаас Тэрэлжийн амралт хүртэл барих асфальтобетон замын ажил эхлэв.

1975 онд СнЗ-ийн 253-р тогтоол /5-р сарын 23-нд/ гарч УБ хотын ГЗ-ны харьяа Зам, далан суваг ашиглалтын конторыг ББМҮЯ-ны ЗГБТ-ийн төвийн замын ангитай нэгтгэж "УБ хотын зам барилга, ашиглалтын контор" болгон ЗГБТ-ийн харьяанд ажиллуулж УБ хотын дэвсгэр дэх зам, гүүр, далан сувгийн ашиглалт засвар үйлчилгээ болон зам, гүүр, далан сувгийн барилга барих ажлыг хариуцуулж ЗГБТ-ийг ББМҮЯ, УБ хотын ГЗ-ны хоёрдмол удирдлагад оруулжээ. 1977-1980 онуудад Тэрэлжийн чиглэлд 15 км, Дэнжийн 1000-ын 1,2 км, Дамбадаржаа чиглэлд 1,7 км, Шаргаморьт, Дарь-Эх, Яармаг, Баруун наран чиглэлд жижиг замууд, Их тойрогт 2,0 км замууд 1981, 1982 онуудад Баянзүрхийн 4,1 км замд шинэчлэлт өргөтгөл хийж, Телевиз-Баянхошууны хооронд 6,2 км, 19-р хорооллийн араар 1,4 км зам барьж, Яргайт, Жигжид, Шаргаморьтын зарим амуудад зам баригджээ.

1982-1986 оны хооронд Нисэхийн замаас Зуун мод хүртэл 25 км, Тэрэлжийн чиглэлд 17,7 км, Улиастайгаас Гацуурт хүртэл 10 км асфальтобетон замууд, Сэлбийн Шаргаморьтын 54 у/м, Хойд Их тойруугийн зам 55 у/м, Баруун нарангийн замд Толгойтын 54 м, 36 м-ийн урттай төмөр бутон гүүрүүд, Махкомбинатын араар дээрх гүүрүүдийг холбосон 2,7 км зам баригджээ.

Монгол, Зөвлөлтийн Засгийн газар хоорондын 1986 оны 1-р сарын 15-ны хэлэлцээрээр ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжаар 950 у/м төмөр бетон гүүр барихаар болж, үүний дотор нэр заагдаж орсон УБ хотын гүүрэн гарцыг хотын баруун гурвалжинд төмөр зам дээгүүр барьж /120 метр урттай, 2 урсгалтай/ 1989 онд ашиглалтанд оруулжээ. Мөн Туул голын Их тэнгэрт 252 м урттай 21 м урт дам нуруутай төмөр бетон гүүрийг 1994 онд ашиглалтанд оруулсан юм.

УБ хотод троллейбусны 40 км шугам тавихтай холбогдуулан Москвагийн "Гипрокоммундортранс" институтээр хотын доторх гол гол 26,4 км гудамж замуудыг өргөтгөн шинэчлэх зураг хийлгэн төсвийг нь Зам гүүрийн зураг төслийн институт хийж гудамж замыг өргөтгөхөд шаардагдах материал, машин механизм нийлүүлэх, мэргэжилтэн авч ажиллуулахад 1987-1988 онд 4 сая 961 мян рублийн контракт байгуулж УБ хотын захиалгаар гудамж замын өргөтгөл шинэчлэлтийг инженер Д.Баасанхүү захиралтай "Зам барилга ашиглалтын трест", Д.Насанжаргал даргатай "Аэродромын барилга контор" уг замуудын дагуух

Толгойтын сувгийн хос гүүр, Чингэлтэй, Хайлаастын төмөр бетон гүүрүүдийг Хөдөлмөрийн баатар Д.Базаргүр захиралтай "Гүүр барилгын контор"-ын зам гүүрийн барилгачид барив. Энэ ажилтай холбогдуулан 1987-1990 онуудад 3 ээлжээр Толгойтоос Баруун 4-н зам хүртэлх Энхтайваны гудамжны баруун хэсэг- 6,4 км, Гагарины гудамж /2 салаа зам/- 0,92 км, Толгойтын замаас Тоосгон завод хүртэлх зам- 2,7 км, Шастины больницийн уулзвараас Горькийн гудамж хүртэлх /2 салаа зам/- 1,655 км, Толгойтын шуудууны 36 м урттай хос 2 төмөр бетон гүүр, Баруун 4-н замаас Амгалан хүртэл /үүний дотор Жуковын өргөн чөлөөний 3,3 км-т хоёр хос замыг нэг замд тооцсоноор/- 7,95 км, Горькийн гудамж /БММЗавод хүртэл/- 1,80км, Ленины өргөн чөлөө- 3,89 км, Баруун 4-н замаас 32-ын тойргоор 7 буудал хүртэлх зам- 6,65 км, Ногоон нуурын урд тойргоос Тасганы овооны ухмалаар Гагарины гудамж хүртэл- 1,2 км, Мөн замын уулзвараас хойд их тойргоор зүүн 4-н зам хүртэл гудамж зам-3,74 км, Чингэлтэй, Хайлаастын Хятадын барьсан жижиг бетон гүүрүүдийг тус бүрийг 18 м урт дам нуруутай, 14 м төмөр бетон гүүр болгон шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

СнЗ-ийн дэргэдэх Авто замын ерөнхий газар, УБ хотын АДХГЗахиргаа хамтран Засгийн газарт асуудал оруулж хотын доторх зам, гүүр, далан сувгийн засвар ашиглалтыг УБ хотын мэдэлд шилжүүлэхээр СнЗ-ийн 1987 оны 2-р сарын 06-ны өдрийн тогтоолоор шийдвэрлэсэн байна. Энэ тогтоолын дагуу Авто Замын Ерөнхий газар тусгай комисс томилон УБ хотын комисст авто зам гүүр, машин механизм ажиллах хүчийг 1987 оны 2-р сард тусгай актаар хүлээлгэн өгчээ.

Байгууллагын түүх

Нийслэл Улаанбаатар хотын хүн ам механик өсөлт сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж, үүнтэй холбоотойгоор замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэл, зорчигчдын тоо эрс өсөв. Энэ нь хотын авто замын ачаалал ихсэх үндсэн шалтгаан болж, зам ачааллаа дийлэхгүй байх, замын эвдрэл гэмтэл, замын түгжрэл бий болох, авто замын осол гарах зэрэг сөрөг үзэгдэлд хүргэх болсон. Иймд Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, авто замыг шинээр барих болон өргөтгөн шинэчлэх, авто замын боловсронгуй систем бий болгох шаардлага зүй ёсоор тавигдах болсон учраас Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын харъяа Замын албыг Монгол улсын

Засгийн газрын 2005 оны 1 сарын 19-ний өдрийн 15 тоот тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газрыг байгуулсан болно. 2005 оноос өмнө тус газар нь 2002-2004 оны 8-р сар хүртэл Нийслэлийн Зам Тээврийн газрын Замын алба, 2004 оны 8-р сараас 12-р сар хүртэл Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Замын алба гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байсан.

Газрын эрхэм зорилго

Нийслэлийн авто замын сүлжээг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хөгжүүлэх, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын чанарыг дээшлүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, иргэдийн ая тухтай зорчих нөхцлийг хангах.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар нь Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулан, авто зам, замын байгууламжийг шинээр барих, өргөтгөн шинэчлэх, засварлах, арчлан хамгаалах ажлыг зохион байгуулж, ажлын явцад технологийн болон лабораторийн хяналт тавьж гүйцэтгүүлэх, нийслэлийн авто замын санг бүрдүүлэх, гэнэтийн болон байгалийн гамшгийн улмаас авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл саатлыг засварлан сэргээн засварлах ажлыг зохион байгуулах, авто замын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, авто зам, замын байгууламжийн зургийн даалгавар боловсруулах, авто замын ашиглалтын байдалд хяналт тавьж, авто замын ачааллын судалгаа хийх, замын хөдөлгөөнийг зохион байгуулах, авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн санг хөтлөн ажиллуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн өмчийн төсөвт байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Авто замын газар нь нийслэл хотын хэмжээнд нийт 427.6 км авто зам / асфальтан зам 366.9 км, бетон зам 60.7 км /, 61ш гүүр /төмөр бутон гүүр 60ш, модон гүүр 1ш/, 52 уулзварын гэрлэн дохионы засвар арчлалт хамгаалалтын ажлыг хариуцан ажиллаж байна. Мөн 117 км 9 чиглэлийн авто замыг гэрээгээр

байнгын арчлалт хамгаалалтад авч, хотын хэмжээнд инженерийн шугам сүлжээтэй холбоотойгоор зам сэтлэх ажилд хяналт тавих, авто замын хөдөлгөөн зохион байгуулалтын менежментийг сайжруулах болон гэр хорооллын авто замын нөхцлийг сайжруулах асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагууд болон авто зам, замын байгууламжийг барих, засварлах ажлаар мэргэжлийн 40 гаруй гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Газар нь эрхэм зорилго, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийн хүрээнд 2005 оноос хойш хийж гүйцэтгэсэн ажлаас товчхон авч үзвэл,

НЗД-ын 2005 оны 142 тоот захирамжаар нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар **2005 онд** хэрэгжүүлэх авто зам болон гүүрийн барилга, байгууламж, төсөл арга хэмжээний санхүүжилтэд 2815.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулан санхүүжилтэд 2900.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд: Хасбаатарын гудамжийг Хувьсгалчдын өргөн чөлөөтэй холбох авто зам /0.33 км/7м/, Хандгайт-Санзай чиглэлийн 4 км авто зам, Багахангай дүүргийн 4.7 км авто замын зэрэг ажлууд хийгдсэн байна. Мөн Их тойруугийн Баянбүрдийн уулзвар дахь ус зайлуулах шугам, замын засварын хамт, Их сургуулийн гудамжийг 32-ын тойрогтой холбох 0.8 км авто зам, Энхтайваны гүүрийн их засварын ажлын зарим хэсгийг ажил хийгджээ. 2005 онд авто зам, гүүрийн засвар арчилгаа, тэмдэг тэмдэглэгээний ажилд 674.4 сая төгрөг зарцуулсан байна.

2006 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр хотын авто зам, замын байгууламжийн барилга, засвар, арчлалтын ажилд нийт 3082.0 сая төгрөг батлагдсаны дагуу ажилласан байна. 2006 онд Их нарангийн 1.4 км авто зам, Их сургуулийн гудамжийг 32-ын тойрогтой холбох 0.8 км авто зам, Амарсанаагийн гудамжны авто замын шинэчлэлт, Токиогийн гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгчээ. Мөн Халдвартын эмнэлгийн арын 0.4 км авто замын өргөтгөл шинэчлэлт, Дамбадаржаагийн авто замыг Тоосгоны үйлдвэртэй холбох 1.7 км авто зам, Бэлх-Сэлбийн 2.2 км авто зам, Чандмань төвийн зүүн талын авто замыг Их тойруу Баянбүрдийн уулзвартай холбох 0.7 км авто зам, Үйлдвэрчний эвлэлийн 1.3 км замын шинэчлэлт, Эрхүүгийн гудамжийг Содномын гудамжтай холбох 0.46 км авто зам, Олимпийн гудамжны уулзварын өргөтгөл, Дамдинсүрэнгийн гудамжийг

Олимпийн гудамжтай холбох 50 у/м гүүр, 0.55 км авто замын шинэчлэлт зэрэг ажлуудын зарим хэсэг хийгдсэн байна. 2006 онд гадаадын зээл тусламжаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд: Энхтайваны 380 у/м гүүрийг Хятад улсын Ху Нань зам гүүрийн барилгын компани гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгсөн. Нийтийн аж ахуйг сайжруулах төслийн хүрээнд СХД-ийн 13-р хороо 1-р хорооллийн арын дэнжийн 0.601 км зам, 18 у/м гүүрийн ажил, БНСУ-ын хөрөнгө оруулалтаар Сөүлийн гудамжны 1.2 км авто замын шинэчлэлт, “Улаанбаатар хоын замын хөдөлгөөний менежментийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Олимп, Токиогийн гудамжны уулзварын өргөтгөл шинэчлэлт, Дунд голын уулзвар, Циркийн арын замын өргөтгөл шинэчлэлтийн ажлууд хийгджээ.

2006 онд 604.5 сая төгрөг хотын авто замын засвар арчлалт, хамгаалалтын ажилд батлагдсаны дагуу засварын ажлыг нийт 27 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна.

2007 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 24 чиглэлийн 29.89 км авто замыг шинээр барьж, өргөтгөл шинэчлэлт хийн, хотын авто зам, хорооллийн доторхи авто замыг засварлах, гэрэл дохио, тэмдэг тэмдэглэгээний засвар, арчлалт болон хотын авто замын сүлжээг сайжруулах бусад ажилд мэргэжлийн 40 аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан, нийт 20.2 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэж, НЗД-тай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ 94.3 хувьтай биелүүлж ажиллажээ.

2008 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8.0 тэрбум төгрөгийн ажилд хяналт тавин сүнхүүжүүлсэн байна. Үүнд: 20-иод объектийн зураг төсөл боловсруулах, 7.42 км авто зам шинээр барин, он дамжсан зарим замын өргөтгөн шинэчлэлт, төв болон хорооллын доторхи авто замын урсгал засвар, гэрэл дохио, тэмдэг тэмдэглэгээний засвар, арчлалт зэрэг авто замын сүлжээг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Цаашид тус газар нь Улаанбаатар хотын авто замын сүлжээг хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хөгжүүлэх, Авто замын сүлжээний мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын чанарыг дээшлүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөлтийг гарган ажиллаж байна.

Газар нь 3 хэлтэс /Захиргаа, Төлөвлөлт, Санхүүгийн хэлтэс, Зам Барилгын хяналтын хэлтэс, Замын Ашиглалт, хөдөлгөөн зохион байгуулалтын хэлтэс/, 2 нэгж /Замын Материал шинжилгээний лаборатори, Шалган бүртгэх товчоод/ гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэлтэс, нэгжүүдийн ажлын чиглэл

Захиргаа, Төлөвлөлт, Санхүүгийн хэлтэс

Нийслэлийн Авто замын газрын Захиргаа, Төлөвлөлт, Санхүүгийн хэлтэс нь Монгол улсын Засгийн газар, НЗД-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт, Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Авто замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын авто замын сүлжээний ойрын болон хэтийн төлөвлөлтийг боловсруулах, хөдөлгөөний менежментийг сайжруулах, авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санг хөтлөн ажиллуулан баяжуулах, улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх авто замын төсөл хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, барилга, засвар арчлалтын ажил гүйцэтгэх, түүнд лабораторийн шинжилгээ хийх, нийслэлийн замын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх болон дээд газрын тогтоол шийдвэр, хөтөлбөр, зорилт, төсөл арга хэмжээний биелэлтэнд хяналт тавьж, биелэлтийг гаргах, замын барилга, засвар арчлалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, санхүүжүүлэх, байгууллагын дотоод ажлыг зохион байгуулах үүрэгтэй ажилладаг.

Зам Барилгын хяналтын хэлтэс

Нийслэлийн Авто замын газрын Зам Барилгын хяналтын хэлтэс нь улсын болог орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, замын сангийн хөрөнгөөр Улаанбаатар хотод шинээр барих болон өргөтгөл шинэчлэлт хийгдэх авто зам, гүүрийн барилгын ажлыг удирдлагаар ханган ажлын явц, чанар, санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй ажилладаг.

Замын Ашиглалт, хөдөлгөөн зохион байгуулалтын хэлтэс

Нийслэлийн Авто замын газрын Замын Ашиглалт, хөдөлгөөн зохион байгуулалтын хэлтэс нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, замын сангийн хөрөнгөөр Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийг засварлах, арчлан хамгаалах, ашиглалтад хяналт тавьж, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, авто замыг хууль бусаар ашигласан, эвдэж сүйтгэсэн

У

тохиолдолд арга хэмжээ авах, холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх, авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангах, замын хөдөлгөөний менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, авто замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио, тэмдэг тэмдэглэгээний барилга, засвар арчлалтын ажлыг хариуцан зохион байгуулах, нийслэлийн замын санг нэмэгдүүлэх шинэ эх үүсвэрүүдийг бий болгох, гэнэтийн болон байгалийн гамшгийн улмаас авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл саатлыг засварлан сэргээх ажлыг зохион байгуулах үүрэгтэй ажилладаг юм.

Замын материал шинжилгээний лаборатори

Нийслэлийн Авто замын газрын дэргэдэх Замын материал, шинжилгээний лаборатори нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, замын сангийн хөрөнгөөр Улаанбаатар хотод шинээр барьж байгаа болон өргөтгөл шинэчлэлт, засвар хийгдэж байгаа зам, гүүрийн ажлын хийц бүтээцэд туршилт, шинжилгээний ажлыг хийх, авто зам, гүүрийн техник ашиглалтын түвшин тогтоох, орцын нормыг тогтоох, барилгын объект дээр нь лабораторийн хэмжилт, шалгалт, хяналт хийх, дүгнэлт гаргах үүрэгтэй.

Шалган бүртгэх товчоод

Нийслэлийн Авто замын газрын Шалган бүртгэх товчоо нь Улаанбаатар хот руу орж байгаа авто тээврийн хэрэгслээс авто зам ашигласны хураамж хураан авч Нийслэлийн замын санг бүрдүүлэх, Шалган бүртгэх товчоодын хэвийн үйл ажиллагааг хангах, тэдгээртэй холбогдсон ажил үйлчилгээг сайжруулахад чиглэгдсэн ажил үйлчилгээ явуулах үүрэгтэй ажилладаг.

Хөмрөгийн түүх

Тус газар нь Нийслэлийн Зам Тээврийн газрын Замын алба /2002-2004 оны 8-р сар/, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Замын алба/2004 оны 8-р сараас 12-р сар хүртэл/ гэсэн нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаад Монгол улсын Засгийн газрын 2005 оны 1-р сарын 19-ны тогтоолоор НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар болж зохион байгуулагдсан. Иймээс байгууллагын 1999-2009 оны хооронд УБ хотод хийгдсэн авто зам, замын байгууламжийн баримт хадгалагдаж байна. Энэ нь шинээр болон өргөтгөн шинэчлэн барьсан авто зам, замын байгууламжийн болон авто зам, гүүрийн зураг

төслийн баримт юм. Мөн нийслэл хотын гудамж замуудад хийгдсэн зам засварын ажлын баримтууд байна.

Хөмрөгийн баримтын тодорхойлолт. Газрын архивт байгууллагын дотоод үйл ажиллагааны болон үндсэн үйл ажиллагааны байнга хадгалах 328 хадгаламжийн нэгж, авто зам, гүүрийн 95 объектийн зураг төслийн 224 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Газар нь тусгай өрөөнд зориулалтын тавиур дээр архивын баримтаа зориулалтын дагуу байршуулан хадгалдаг.

НАЗГ нь 2005 онд байгуулагдсан бөгөөд одоогоор төрийн архивт хөмрөг үүсгээгүй байна. УТА-ын Зураг төслийн баримтын төвд 1986-2002 оны авто замын зураг төслийн 119 хадгаламжийн нэгж шилжүүлсэн.

Хөмрөгийн эрдэм шинжилгээний лавлахын хувьд Авто замын ажлын гүйцэтгэлийн баримт болон зураг төслийн баримтаар байнга хадгалах баримтын данс үйлдсэн.

Хөмрөгийн баримтаас тус газрын ИТА-ууд болон салбарын сонирхогч байгууллагуудад бүртгэл хөтлөн ашиглуулж байна.

Архивын эрхлэгч



/Э.Бат-Эрдэнэ/